

**ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СОНГОН,
СЕКЦ, ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА, СУРГАЛТЫН ЧАНАР
ХҮРТЭЭМЖ, ҮНЭ ТӨЛБӨРИЙН
НӨХЦӨЛ БАЙДАЛ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч: ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
Гүйцэтгэгч: “ЭС АЙ СИ ЭЙ” ХХК

УЛААНБААТАР ХОТ 2019 ОН

Судалгааны багийн ахлагч: П.ЦЭРЭНБАЗАР /“Эс Ай Си Эй” ХХК-ны зөвлөх/

Судлаачид: Х.ДОЛГОРМАА /“Эс Ай Си Эй” ХХК-ны мэдээлэл
цуглуулалт боловсруулалтын хэлтсийн ахлах менежер/
Б.ХИШИГБАЯР /“Эс Ай Си Эй” ХХК-ны
боловсруулалтын хэлтсийн менежер /

Тайланг хянасан: Г.ЭРДЭНЭ /“Эс Ай Си Эй” ХХК-ны Судалгаа
шинжилгээний газрын захирал/

Тайлан бичсэн: Э.ДОЛЖИН /“Эс Ай Си Эй” ХХК-ны Нийгмийн
судалгааны хэлтсийн менежер/
Н.ЭНХСАРНАЙ /“Эс Ай Си Эй” ХХК-ны Бизнесийн
судалгааны хэлтсийн менежер/

АГУУЛГА

Графикын жагсаалт	4
Зургийн жагсаалт	5
Хүснэгтийн жагсаалт	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	6
БҮЛЭГ 1. АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	8
1.1 Хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл	8
1.2 Зорилго, зорилт	8
1.3 Хамрах хүрээ, оролцогч талууд	9
1.4 Судалгааны төрөл, мэдээлэл цуглуулах арга	9
1.4.1 Тоон судалгаа	10
1.4.2 Чанарын судалгаа	11
1.4.3 Баримт бичгийн шинжилгээ	12
1.5 Мэдээлэл боловсруулалт	12
БҮЛЭГ 2. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	15
2.1 Ерөнхий статистикууд	15
2.2 Сургуулиас гадуурх үйл ажиллагааны талаарх хууль, эрх зүй бодлогын орчны өнөөгийн байдал	19
2.3 Сэдвийн судлагдсан байдал	21
2.4 Олон улсын сайн туршлагууд	24
2.4.1 Олон улсын боловсролын үнэлгээний тухай	24
2.4.2 Харьцуулалт	35
БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	38
3.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	38
3.2 Сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн нэр төрөл, үнэ төлбөр	39
3.2.1 Үйл ажиллагаа, нэр төрөл	39
3.2.2 Үнэ төлбөр	43
3.3 Сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн чанар хүртээмж	44
3.3.1 Сэтгэл ханамжтай байдал	44
3.3.2 Хэрэгцээ, шаардлагыг хангасан байдал	47
3.3.3 Одоогийн дугуйлан, сонгон секцийг сонгосон шалтгаан	50
3.4 Сурагчдын цаашдын хүсэл, сонирхол	52
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	55
ХАВСРАЛТ	59
Судлаач бэлтгэх сургалтын зураг	59
Фокус бүлгийн ярилцлагын үеэрх зураг	59
Асуулгын хуудас	61

ГРАФИКЫН ЖАГСААЛТ

- График 1. Улаанбаатар хотын дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж буй сурагчдын тоо, *дүүргээр*
- График 2. Олон улсын сурагчдын шинжлэх ухааны холбогдолтой үйл ажиллагааны оролцоо, *хувиар*
- График 3. Боловсролын чанараар тэргүүлэгч топ-10 улсын сурагчдын нэг долоо хоногт хичээлээс гадуурх үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа, *цагаар*
- График 4. ЕБС-аас дээд сургууль хүртэл нэг суралцагчид ногдох зардлын хэмжээ, *мянган ам. доллароор*
- График 5. “Олон улсын сурагчдын боловсролын түвшингийн үнэлгээ (PISA)” 2015 оны үзүүлэлт
- График 6. Дугуйлан, сонгон, секцэд хамрагдах байдал, *хүйсийн харьцаагаар*
- График 7. Улаанбаатар хотын сурагчдын дугуйлан, сонгон, секцэд хамрагдах байдал, *нэр төрлөөр*
- График 8. Орон нутгийн сурагчдын дугуйлан, сонгон, секцэд хамрагдах байдал, *нэр төрлөөр*
- График 9. Төлбөртэй дугуйлан, сонгон, секцийн 1 сарын үнэ, *төгрөгөөр*
- График 10. Сурагчдын сэтгэл ханамж, *хувиар*
- График 11. Сурагчдын сэтгэл ханамж, *хүйсийн харьцаагаар*
- График 12. Сурагчдын сэтгэл ханамж, *дугуйлан, сонгон, секцийн байршлаар*
- График 13. Сурагчдын сэтгэл ханамжийн түвшин 39
- График 14. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал, *хамрагдаж буй байршлаар*
- График 15. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал
- График 16. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал, *хувиар*
- График 17. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал, *хүйсийн харьцаагаар*
- График 18. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал, *байршлаар*

График 19. Одоогийн хамрагдаж буй дугуйлан сонгон, секцэд хамрагдсан шалтгаан

График 20. Одоогийн хамрагдаж буй дугуйлан сонгон, секцэд хамрагдсан шалтгаан, *хүйсийн харьцаагаар*

График 21. Одоогийн хамрагдаж буй дугуйлан сонгон, секцэд хамрагдсан шалтгаан, *байршлаар*

График 22. Цаашид хамрагдахыг хүсэж буй дугуйлан, сонгон, секцийн төрөл

График 23. Цаашид хамрагдахыг хүсэж буй дугуйлан, сонгон, секцийн төрөл, *байршлаар*

График 24. Цаашид хаана дугуйлан, сонгон, секц хичээллэх нь илүү үр дүнтэй байх, *хувиар*

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны төрөл

Зураг 2. Чанарын судалгааг хийх арга зүй

Зураг 3. Баримт бичгийн шинжилгээ хийх арга зүй

Зураг 4. Дугуйлан, сонгон, секцэд хамрагддаг сурагчдын тоо, *хамрагдаж буй байршлаар*

Зураг 5. Сурагчдын сүүлийн 1 жилийн хугацаанд хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцүүд

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Түүврийн хуваарилалт
- Хүснэгт 2. ФБЯ-ын хуваарилалт
- Хүснэгт 3. Ганцаарчилсан ярилцлагын хуваарилалт
- Хүснэгт 4. ЕБС-ийн тоо, *бүс нутгаар*
- Хүснэгт 5. ЕБС-ийн сурагчдын тоо, *мянгаар*
- Хүснэгт 6. ЕБС-ийн багш нарын тоо
- Хүснэгт 7. Боловсролын салбарт зарцуулж буй зардал
- Хүснэгт 8. Монгол Улсын хэмжээнд хичээллэж буй дугуйлан, сонгон, секц болон хамрагдаж буй сурагчийн тоо
- Хүснэгт 9. Дэлхийн боловсролын чанарын жагсаалт “Олон улсын сурагчдын боловсролын түвшингийн үнэлгээ”-ээр тэргүүлэгч Топ-10 улс
- Хүснэгт 10. Олон улс орны сургуулиудын санал болгодог сургуулиас гадуурх үйл ажиллагааны төрлүүд
- Хүснэгт 11. Боловсролын чанараар тэргүүлэгч топ-10 улсын сурагчдын хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагддаг байдал, *хувиар*
- Хүснэгт 12. Ёонгсан сургуулийн санал болгодог сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн төрлүүд
- Хүснэгт 13. Финланд улсын сурагчдын ерөнхий мэдлэгийн үзүүлэлтүүд
- Хүснэгт 14. Финланд улсын сургуулиас гадуурх үйл ажиллагааны төрлүүд
- Хүснэгт 15. Өмнөд Солонгос болон Финланд улсын ерөнхий үзүүлэлтүүдийн харьцуулалт
- Хүснэгт 16. Сургуулиас гадуурх хамрагддаг үйл ажиллагааны харьцуулалт, *хувиар*
- Хүснэгт 17. Харьцуулалт
- Хүснэгт 18. Судалгаанд хамрагдсан сурагчдын ерөнхий мэдээлэл
- Хүснэгт 19. Дугуйлан, сонгон, секцийн ангилал
- Хүснэгт 20. Сүүлийн 1 жилийн хугацаанд сурагчдын дугуйлан, сонгон, секцэд хамрагдсан байршил
- Хүснэгт 21. Дугуйлан, сонгон, секцийн төлбөр, *байршлаар*
- Хүснэгт 22. Сурагчдын сэтгэл ханамжийн түвшин, *нэр төрлөөр*
- Хүснэгт 23. Хэрэгцээ, шаардлагыг хангасан байдал, *нэр төрлөөр*

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
МУ	Монгол Улс
ОУ	Олон улс
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХГҮА	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ШУ	Шинжлэх ухаан
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
PISA	Programme for International Student Assessment

БҮЛЭГ 1: АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэ бүлэгт судалгааг хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл, зорилго, зорилт, хамрах хүрээ, судалгааны төрөл болон судалсан мэдээлэлд боловсруулалт хийсэн арга зэргийг багтаалаа.

1.1. ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг 2018-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.2-т Хүүхдэд чиглэсэн сургалт, хөгжүүлэх ажлын нэр төрлийг нэмэгдүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр “Сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагаа, сургалтын чанар хүртээмж, үнэ төлбөрийн байдалд, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах” (2.2.1), “Хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр иргэд байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа, үнэ төлбөрт жил бүр үнэлгээ хийж, дүгнэлт гаргах” (2.2.2) ажлууд тусгагдсан.

Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлээс гадуурх үйл ажиллагаа (ХГҮА) нь БСШУС-ын сайдын тушаалаар батлагдсан ХГҮА-ны цөм хөтөлбөр зөвлөмжийн дагуу зохион байгуулагддаг, нийт танхимын цагийн 2.9 хувийг эзэлдэг. Тус хичээл нь “сургагч хамт олны үйл ажиллагааны явцад өөртөө итгэлтэй, өөрийгөө удирдах, хөгжүүлэх, бусдыг манлайлах чадвартай хөгжилтэй, эвсэг хамт олныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг бүтээлч, санаачилгатай, байгуулах байдал давамгайлж байна гэж дүгнэсэн.

Хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр сургууль, хүүхдийн ордон, хөгжлийн төвүүд, хувийн хэвшил, байгууллага, иргэд олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг боловч, эдгээрийг үр өгөөж, үнэ төлбөр, нэр төрөл зэргийг судалж үнэлгээ хийх, цаашид ямар төрлийн үйлчилгээг ямар байгууллагаар дамжуулж хүргэх нь өнөөгийн хүүхдийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагад нийцэх эсэхийг судлах шаардлага байсаар байгаа нь энэхүү судалгааг хэрэгжүүлэх шаардлага, үндэслэлийг бүрэн илэрхийлж чадаж байна.

1.2. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хичээлээс гадуурх сонгон, секц дугуйлангийн үйл ажиллагааны цар хүрээг тогтоох, хүүхдэд чиглэсэн сургалт, хөгжүүлэх ажлын нэр төрлийг нэмэгдүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх, хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөгжлийн үйлчилгээний нэр төрлийг тодорхойлох, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанд

тусгахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино. Судалгааны зорилгыг хангаж ажиллахын тулд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаа.

- Хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн сургууль, иргэд, байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны чиглэл, хэлбэр, нэр төрлийг тодорхойлох,
- Сургалтын чанар, үр өгөөж, үнэ төлбөрт үнэлгээ хийх,
- Сонгон секц дугуйлан, хөгжлийн үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох,
- Бусад улс орнуудын сургуулиас гадуурх сонгон секц, дугуйлан хөгжлийн үйлчилгээний төлөв байдал сайн туршлагыг судлах,
- Судалгааны үр дүнгээр тайлан, зөвлөмж санал боловсруулах

1.3. ХАМРАХ ХҮРЭЭ, ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Цаг хугацааны хувьд: 2019 оны 10-11 дүгээр сард судалгааг гүйцэтгэсэн.

Байршлын хувьд: Монгол Улсын хэмжээнд уг судалгааг хийлээ. Ингэхдээ төлөөлөх чадвар бүхий бүс нутгийн төлөөлөл болсон 4 аймаг, Улаанбаатар хотыг хамруулсан.


Асуулгын хувьд: Судалгааны оролцогч талуудыг тодорхойлсны үндсэн дээр оролцогч талуудын онцлогт тохирсон чиглүүлэх асуулт бүхий асуулгын хуудаснуудыг боловсруулсан.

Оролцогч талууд: Судалгааны баг оролцогч талуудыг дараах байдлаар тодорхойлсон.

1. ЕБС-ийн сурагчид
2. Сонгон, секц, дугуйланд хамрагдаж буй сурагчид
3. Эцэг эхийн төлөөлөл
4. Сонгон, секц дугуйлангийн удирдлага
5. Сургуулийн багш нар
6. Судалж буй салбарын эксперт

1.4. СУДАЛГААНЫ ТӨРӨЛ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА

Судалгааг гүйцэтгэхдээ анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг ашигласан.



Зураг 1. Судалгааны төрөл

1.4.1. Тоон судалгаа

Судалгааны эх олонлог нь ЕБС-д суралцагчдын тоогоор хэмжигдэж байгаа бөгөөд түүврийн эх олонлогоо төлөөлөх чадварыг үндэслэн түүврийн хэмжээг 390 байхаар тодорхойлсон. Түүвэр нь Монгол Улсын хэмжээнд хийгдэх тул бүс нутгийг төлөөлөх чадвар бүхий 4 аймаг болон Улаанбаатар хотыг хамруулан түүврийг тархаасан.

Сонгогдсон 4 аймагт Ховд, Булган, Төв, Хэнтий аймгууд багтаж байгаа бөгөөд сонголтыг хийхдээ санамсаргүй сонголтын аргыг ашигласан болно.

Түүврийн хуваарилалт

Түүврийн хуваарилалтыг хийхдээ аймаг, хотуудын сургуулийн тоо болон дугуйлан, сонгон, секцийн тоог харгалзан үзсэн. Мөн дугуйлан, сонгон, секцэд хамрагддаг болон хамрагддаггүй сурагчдаас судалгааг авсан.

Түүнчлэн аймаг, хотуудад түүврийг тархахдаа сум болон дүүргийг хамруулсан. Сонгогдсон аймгуудын төвөөс гадна 1 сумыг сонгож судалгаанд хамрууллаа. Ийнхүү түүврийг тархаасныг тараах хүснэгтэд харуулж байна.

Хүснэгт 1. Түүврийн хуваарилалт

Аймаг, хотын нэр	Сум, дүүргийн нэр	Нийт түүвэр
Ховд	Ховд (Жаргалант)	33
	Буянт	24
	Нийт	57
Булган	Булган	30
	Орхон	22
	Нийт	52
Төв	Зуунмод	30
	Батсүмбэр	26
	Нийт	56
Хэнтий	Хэрлэн	36
	Өмнөдэлгэр	24
	Нийт	60
Улаанбаатар	Баянзүрх	41
	Сүхбаатар	42
	Баянгол	41
	Багануур	41
	Нийт	165

Дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж буй сурагчдаас дараах байдлаар ангилан судалгаа авсан.

- Урлан бүтээх төв - СБД
- Хүүхдийн ордон - СБД
- Биеийн тамир, спортын хороо
- Бусад

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд дараах зарчмын баримтлан ажилласан. Үүнд:

- Орон нутгийн ЕБС-ийн сургуулийн сурагчид сонгохдоо аймгийн тухайд 2 хүртэлх сургуулийг хамруулсан. Сурагчдыг насны бүтцээр нь ангилан бага, дунд, ахлах бүлгийн төлөөллийг тэнцүү тоогоор хамруулахыг зорьсон. Дугуйлан, сонгон, секцэд хамрагддаг сурагчдыг мөн бага, дунд, ахлах бүлэг хэмээн ангиллаа.
- Хотын захын сургуулиудын сурагчдыг тодорхой тоогоор хамруулсан. Дугуйлан, сонгон, секцэд хамрагддаг сурагчдыг сонгохдоо урлан бүтээх төв, хүүхдийн ордон гэх мэт төрийн байгууллагын төлөөллөөс хамрууллаа.
- Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн тоог тэнцүү хамруулахыг зорьсон.

1.4.2. Чанарын судалгаа

Чанарын судалгааг хийхдээ фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага хийх нь илүү үр дүнтэй гэж үзлээ.

Фокус бүлгийн ярилцлага: Улаанбаатар хот болон орон нутагт нийт 6 удаагийн ФБЯ хийсэн. Ингэхдээ ЕБС-ийн багш нарыг хамруулсан. Уг ярилцлагыг зохион байгуулахдаа чиглүүлэх асуултын хүрээнд хийсэн бөгөөд чиглүүлэх асуултыг захиалагч талд танилцуулан саналыг тусгасан болно.

Хүснэгт 2. ФБЯ-ын хуваарилалт

№	Байршил	Зорилтот бүлэг	Ганцаарчилсан ярилцлагад оролцогчийн тоо	Авах мэдээллийн агуулга
1	Баянзүрх	Улаанбаатар хотын ЕБС-ийн багш нар	1	ХГҮА-ны чанар хүртээмж болон үйл ажиллагааг явуулахад гарч буй хүндрэл, бэрхшээл, цаашид сайжруулахад шаардлагатай зүйлсийн талаар нэмэлт мэдээлэл авсан.
2	Сүхбаатар		2	
3	Баянгол		2	
4	Багануур		1	
1	Ховд	Орон нутгийн ЕБС-ийн багш нар	5	
2	Булган		5	
3	Төв		5	
4	Хэнтий		5	
Нийт 26 төлөөлөл				

Ганцаарчилсан ярилцлага: Ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулахдаа чиглүүлэх асуултыг захиалагч талын саналыг тусгасан. Улаанбаатар хот, орон нутгийг хамарсан нийт 18 ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан.

Хүснэгт 3. Ганцаарчилсан ярилцлагын хуваарилалт

Оролцогчид	Ховд	Булган	Төв	Хэнтий	Улаанбаатар	Нийт
Эцэг, эхийн төлөөлөл	2	2	2	2	2	10
Дугуйлан, сонгон, секцийн удирдлагуудын төлөөлөл	1	1	1	1	1	5
Салбарын эксперт	-	-	-	-	3	3
Нийт	3	3	3	3	6	18

ФБЯ болон ганцаарчилсан ярилцлагыг дараах арга зүйн дагуу явуулсан.

Зураг 2. Чанарын судалгааг хийх арга зүй



1.4.3. Баримт бичгийн шинжилгээ

Судалгааны зорилгын хүрээнд олон нийтэд нээлттэй тоон мэдээ мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг ашигласан ба бусад салбарын хүрээнд хийгдсэн судалгааны тайлантай харьцуулан үр дүнг гаргасан. Мөн ХГҮА-тай холбоотой ОУ-д хийгдсэн судалгаа, тэдгээрийн арга, аргачлалыг судлан анализ хийлээ.

Баримт бичгийн шинжилгээг дараах баримтад хийнэ:

- ХГҮА-ны цөм хөтөлбөр
- Энэ чиглэлээр хийгдсэн судалгааны тайлан, материалууд,
- Олон Улсын сайн туршлага

Баримт бичгийн шинжилгээг дараах арга зүйн дагуу явуулсан.

Зураг 3. Баримт бичгийн шинжилгээ хийх арга зүй



1.5. МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Мэдээлэл боловсруулах үе шатанд дараах программ хангамжийг ашигласан.

- Мэдээллийн оруулах, алдааг шалгах: **CS Pro 7.1**
- Мэдээлэл боловсруулах: **SPSS Software 25.0, IBM8 SPSS,**
- Тайлан боловсруулах: **MS-Office 2016**

Мэдээллийн оруулах, алдааг шалгах: CS Pro 7.1

Мэдээлэл шивэлтийг статистик судалгааны CS Pro 7.1 программ ашиглан хийв. Мэдээлэл оруулах программыг АНУ-ын Тооллогын товчооны боловсруулсан тооллого түүвэр судалгааны CSPro багц программын сүүлийн хувилбарын мэдээлэл оруулах хэрэгсэл¹ болон мэдээллийг шалгах засварлах багцын тусламжтайгаар боловсруулсан. Мэдээлэл оруулах үеийн шалгалтуудыг дараах байдлаар гүйцэтгэхээр программчилсан. Үүнд:

1. Мэдээлэл оруулах явцад хариулт орхигдохоос сэргийлэх үүднээс заавал хариулах асуулт бүр дээр хариултыг заавал оруулахыг сануулах (хэрэв тухайн асуултад үнэхээр хариулаагүй байх тохиолдолд алгасахаар).
2. Хариултад байхгүй код оруулах болон оруулсан утга нь тодорхой хязгаарт багтахгүй байх тохиолдолд анхааруулах.
3. Асуулт хоорондын энгийн уялдаа холбоо, үсрэлтийг автоматчилах.

Программын дагуу мэдээллийг оруулж дууссаны дараа CSPro 7.1 программын алдааг илрүүлэх² хэрэгслийг ашиглан дараах шалгалтуудыг хийв. Үүнд:

1. Ердийн шалгалт: Бүх асуулт бүрэн хариулагдсан эсэх болон үсрэлт зөв байгаа эсэхийг шалгах.
2. Үнэмшилтэй утгын шалгалт: Байж болох утгаас давсан онцгой утга байгаа эсэхийг шалгах.
3. Статистик шинжилгээнд тулгуурласан хамаарлын болон логик шалгалт: Утгуудын хоорондын уялдаа, логик холбоо, утгуудын нийлбэр нийт дүнтэй тэнцүү эсэхийг шалгах.
4. Мэдээлэл оруулах программын шалгалт: Үүнд ердийн шалгалт, үнэмшилтэй утга болон хамаарлын шалгалтууд хамаарна.

Мэдээлэл шалгах программын шалгалт: Мэдээлэл оруулах программын шалгалт ба бусад нэмэлт шалгалтууд. Мэдээллийг оруулж дууссаны дараа CSPro 7.1 программын өгөгдлийг хөрвүүлэх хэрэгслийг ашиглан SPSS³ 25.0 программд хөрвүүлэн мэдээллийн баазыг бэлтгэсэн ба уг баазаас энгийн давтамжуудын хүснэгтийг гаргаж, мэдээллийг дахин шалгасан.

Мэдээлэл боловсруулах: SPSS Software 25.0, IBM8 SPSS, STATA

Судалгааны мэдээлэл оруулах үе шатнаас эхлэн анхдагч засварлалт, ахисан шатны хяналтууд хийгдэж эхэлсэн. Мөн судалгааны үндсэн болон нэмэлт хүснэгтүүдийн алгоритм боловсруулах ажил эхэлж судалгааны мэдээлэл цуглуулах хугацаа дуусаж сүүлийн дата мэдээлэл ирэх үед



¹ Мэдээлэл оруулах хэрэгсэл - Data entry tools

² Алдааг илрүүлэх зорилго бүхий Batch edit хэрэгсэл ашигласан.

³ SPSS - Statistical Package for the Social Sciences

боловсруулж дууссан байна. Мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ энэхүү судалгаанд зориулан боловсруулсан стандарт томъёолол болон үр дүнгийн хүснэгтийн загварыг ашиглана. Мөн асуулгын хуудсанд нийцүүлэн өөрчилсөн нэмэлт хүснэгтүүдийг Нийгмийн шинжлэх ухаанд ашигладаг статистикийн багц програм SPSS 25.0-ийг ашиглан боловсруулсан. Анализ буюу дүн шинжилгээ хийх:

- SPSS: Statistical Package for the Social Sciences



- IBM SPSS: Statistical Product and Service Solutions

Тайлан боловсруулах: MS-Office 2016

Тайлан боловсруулах шатанд MS-Office 2016 программын Word, Excel, Powerpoint программ хангамжийг ашигласан.

БҮЛЭГ 2. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Энэ бүлэгт боловсролын салбарын болон ХГҮА-ны ерөнхий статистик үзүүлэлтүүд, төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрүүд, олон улсын сайн туршлагын хэсгийг багтаалаа.

2.1. ЕРӨНХИЙ СТАТИСТИКУУД

2018 оны байдлаар Монгол Улсад 803 ЕБС байна. Энэ нь 2014 онтой харьцуулахад 5.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Сүүлийн 5 жилийн хугацаанд жил бүр 10-20 тооны сургууль шинээр нэмэгдсэн байна. Эдгээр сургуулийн 70 орчим хувийг ахлах анги хүртэлх бүлгүүдтэй сургууль эзэлж байна.

Сургуулиудыг бүс нутгийн хувьд харьцуулахад Улаанбаатар хотод хамгийн их буюу 245 сургууль байна. Энэ нь нийт сургуулийн 31.0 хувийг эзэлж байгаа юм. Баруун бүс, хангайн бүс, төвийн бүсийн сургуулиудын тоо ерөнхийдөө ойролцоо, харин зүүн бүсийн сургуулийн тоо тэдгээртэй харьцуулахад бага байна.

Хүснэгт 4. ЕБС-ийн тоо, бүс нутгаар

Засаг захиргааны нэгж	2015	2016	2017	2018
Баруун бүс	154	156	156	156
Хангайн бүс	172	172	173	175
Төвийн бүс	158	156	159	158
Зүүн бүс	68	68	68	68
Улаанбаатар	215	225	241	245
БНСУ дахь Монгол сургууль	1	1	1	1
Улсын дүн	768	778	798	803

2018 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 803 сургуульд 593.2 мянган сурагчид суралцаж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар ЕБС-д суралцагчдын тоо жилд 4-6 хувиар нэмэгдэж байна. Энэ нь хүн амын өсөлттэй холбоотой байж болох талтай.

593.2 мянган сурагчийн 1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй сурагчид эзэлж байна. Монгол Улсын хэмжээнд 2018 онд 6,518 хөгжлийн бэрхшээлтэй сурагчид байгаа бөгөөд үүний 45.0 хувийг охид эзэлж байна. Гэвч энэхүү тоо баримт нь 2013 онтой харьцуулахад бараг 3 дахин буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт 5. ЕБС-ийн сурагчдын тоо, мянгаар

Аймаг	2014	2015	2016	2017	2018
Баруун бүс	81.7	84.2	84.0	85.2	85.4
Хангайн бүс	103.3	106.3	108.0	110.0	111.0
Төвийн бүс	81.3	85.1	87.3	89.1	90.9
Зүүн бүс	36.8	38.0	38.9	40.4	41.4
Улаанбаатар	202.5	221.3	233.6	247.8	264.2
БНСУ дахь монгол сургууль	0.2	0.2	0.2	0.3	0.3
Улсын дүн	505.8	535.1	552.0	572.8	593.2

2018 онд 30,411 багш нар ажиллаж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд багш нарын тоо жилд дунджаар 2.5 хувиар нэмэгдсэн байна. Нэг багшид дунджаар 20 сурагч оногдож байна.

Хүснэгт 6. ЕБС-ийн багш нарын тоо

Аймаг	2013	2014	2015	2016	2017	2018
Баруун бүс	4,916	4,919	5,131	5,116	5,109	5,209
Хангайн бүс	5,800	5,785	5,947	5,957	6,030	6,083
Төвийн бүс	4,522	4,593	4,755	4,682	4,751	4,858
Зүүн бүс	2,015	2,024	2,112	2,036	2,071	2,131
Улаанбаатар	9,945	10,119	10,530	11,084	11,268	12,117
БНСУ дахь монгол сургууль	7	9	15	14	13	13
Улсын дүн	27,205	27,449	28,490	28,889	29,242	30,411

Улсын нэгдсэн төсвийн нийт зардал 2014 онд 7.2 их наяд төгрөг байсан бол 2018 онд 9.2 их наяд төгрөг болжээ. Үүнээс боловсролын салбарт зарцуулж буй зардал нь сүүлийн 5 жилд 13-17 хувийг эзэлсээр иржээ. Монгол Улсын 1 иргэнд оногдох боловсролын зардал нь жилд 438.0 мянган төгрөг байна. Эндээс ЕБС-аас эхлээд их, дээд сургууль хүртэлх зардлыг тооцвол 5.3 сая төгрөг болох юм.


Хүснэгт 7. Боловсролын салбарт зарцуулж буй зардал

Төрөл	2014	2015	2016	2017	2018
Улсын нэгдсэн төсвийн нийт зардал, сая төгрөг	7,144,568	7,137,974	9,519,906	9,017,319	9,222,929
Боловсролын зардал№, сая төгрөг	1,190,093	1,000,712	1,222,237	1,204,209	1,382,409
Улсын нэгдсэн төсвийн нийт зардалд боловсролын зардлын эзлэх хувь	17	14	13	13	15
Нэг хүнд ногдох боловсролын зардал, мянган төгрөг	405	336	404	389	438

Монгол Улсын хэмжээнд 2018 оны нэгдсэн дүнгээр нийт 176,742 хүүхэд давхардсан тоогоор 4,410 хичээлээс гадуурх сонгон, секц, дугуйланд сургууль дээрээ суралцаж байна. Уг сургууль дээр хичээллэж буй хичээлээс гадуурх сонгон, секц, дугуйлангийн 271 нь буюу 6.1 хувь нь төлбөртэй байна. Төлбөрийн хэмжээ нь сарын 5.0 мянган төгрөгөөс жилийн 1.2 сая төгрөгийн төлбөртэй байгаа ба ихэвчлэн оюуны болон хөгжмийн боловсрол, хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна. Төлбөртэй хичээллэж байгаа дугуйлан, сонгон, секцийн 76 хувь нь буюу 206 орчим нь сургууль дээр үйл ажиллагаа явуулж байна. Харин үлдсэн 24 хувь нь БТСГ, соёлын ордон, бусад сургалт хөгжлийн төвүүд багтаж байна.

Судалгааны багийн тооцооллоор нийт сурагчдын хэд нь сургууль дээрээ, хэд нь сургуулиас гадуурх дугуйлан, сонгон, секцэд хамрагддагийг дараах зурагт харууллаа. (Зурагт харуулсан 2 тооны нийлбэр нь нийт дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж буй сурагчдын тоог илэрхийлж чадахгүй юм)

Зураг 4. Дугуйлан, сонгон, секцэд хамрагддаг сурагчдын тоо, хамрагдаж буй байршлаар




Дараах хүснэгтэд нэгдсэн мэдээллийг харууллаа. Говь-Алтай, Хэнтий аймгууд мэдээллээ ирүүлээгүй, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ерөнхий боловсролын сургууль мэдээлэл өгөхөөс татгалзсан бол Архангай, Дорноговь, Өмнөговь аймгууд хүснэгтийн дагуу мэдээлэл ирүүлээгүйгээс насны бүлгээр нэгтгэх боломжгүй байжээ.

Хүснэгт 8. Монгол Улсын хэмжээнд хичээллэж буй дугуйлан, сонгон, секц болон хамрагдаж буй сурагчийн тоо

№	Орон нутгийн нэр	Хамрагдаж буй хүүхдийн нас				Дугуйлангийн тоо	Сонгон, секцийн тоо	Нийт
		6-8	9-11	12-14	15-18			
1	Архангай	4,410				19	10	29
2	Баян-өлгий	140	300	235	51	47	4	51
3	Баянхонгор	1,216	1,607	1,180	127	109	18	127
4	Булган	688	1,126	1,817	202	162	40	202
5	Говьсүмбэр	103	189	241	21	16	5	21
6	Дархан	3,055	2,032	2,094	418	364	54	418
7	Дорноговь	890				10	14	24
8	Дорнод	1,457	1,876	2,722	266	173	93	266
9	Дундговь	1,942	2,396	3,608	307	143	164	307
10	Завхан	4,462	2,024	3,886	225	135	90	225
11	Орхон	2,359	2,466	2,711	289	225	64	289
12	Өвөрхангай	691	1,460	1,907	211	137	74	211
13	Өмнөговь	12,588					392	392
14	Сүхбаатар	178	332	403	51	39	12	51
15	Сэлэнгэ	1,921	2,531	3,857	370	339	31	370
16	Төв	3,396	4,686	5,575	537	432	105	537
17	Увс	1,360	1,163	1,565	104	47	57	104
18	Ховд	589	740	1,850	138	79	59	138
19	Хөвсгөл	794	1,254	1,923	463	328	135	463
20	Улаанбаатар	8,232	10,465	11,871	185	151	34	185
Нийт		32,583	36,647	47,445	42,179	3,347	1,063	4,410

Дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж буй Улаанбаатар хотын сурагчдын дийлэнх хувийг Баянгол дүүргийн сурагчид эзэлж байна.

График 1. Улаанбаатар хотын дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж буй сурагчдын тоо, дүүргээр



Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн их сургуультай дүүргүүдэд Баянзүрх (52), Сүхбаатар (46), Баянгол (45), Хан-Уул (39) дүүргүүд орно.

Сурагчдын тоогоор ч мөн эдгээр дүүргүүд бусад дүүргүүдтэй харьцуулахад илүү байх нь ойлгомжтой. Эндээс Баянгол дүүргийн сурагчид Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн сурагчдаас илүү дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж байна.

2.2 СУРГУУЛИАС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ БОДЛОГЫН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Салбарын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага болон холбогдох баримт бичгийн судалгааны үр дүнд хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хүүхэд хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрүүд тодорхой түвшинд хангалттай хэмжээнд батлагдсан байна хэмээн дүгнэлээ. Монгол Улсын боловсролын салбарт сурагчдын сурч боловсрох, хөгжих эрхийг хангах, боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд онцгой анхаарч, стандартад суурилсан боловсролын тогтолцоо бий болгох, сургуулийг хүний хөгжлийн төв болгон хөгжүүлэх зорилгоор дараах бодлого, хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байна.

“Боловсрол” үндэсний хөтөлбөрт

Стратегийн зорилт 1. “Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх”

Стратегийн зорилт 2. “Бүх түвшний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг суралцагчийн хэрэгцээ, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох”

Стратегийн зорилт 4. “Боловсролын тогтолцоог боловсронгуй болгон олон улсын жишигт ойртуулахад төрийн гүйцэтгэх үүрэг, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх”

Бага, дунд боловсролын тухай хуульд

18.1 “Хичээлээс гадуурх сургалтын ажил нь суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авьяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ”

18.2. “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтооно”

18.3. “Сургуулийн захиргаа нь хичээлээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран зохион байгуулна”

Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн шаардлагад “Ерөнхий

боловсролын сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт байгаль орчин, эдийн засаг, нийгэм, соёлын уялдаа холбоог хангасан цогц байдлаар агуулгын болон арга зүйн шийдлийг хийх, суралцагчдад хандлага, үнэт зүйлс, хэрэглээний чадварыг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай”

Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэмд

3.3 “Сургалтын ажил нь хичээл, хичээлээс гадуурх сургалт, хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах тэдгээртэй холбоотой бусад ажлаас бүрдэнэ. Сургууль хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн ажлын төлөвлөгөөтэй ажиллана”

4.1.3. “Багш сургалтын төлөвлөгөөнд заасан хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлын явцад суралцагчдыг хараа хяналтгүй орхихгүй байх нөхцөлийг хангаж ажиллах ба хүүхдийг хүчирхийлэл, хорт зуршил, авто замын болон болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах талаар эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллана”

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт

3.2.13. “Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг нэвтрүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлнэ. Үүнд “Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг боловсруулж, санхүүжүүлэх, Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн тоног, төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах” хэмээн тус тус заасан байна.

Ерөнхийдөө хүүхэд бүрд чанартай, хүртээмжтэй боловсролыг ижил түвшинд хүргэх, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэхийн тулд төрөөс сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах гэх мэт хүүхдийн хэрэгцээнд нийцсэн орчин, нөхцөлийг бүрдүүлж чадахаар бодлого, хөтөлбөр, хууль, эрх зүйн таатай нөхцөл байдал тодорхой хэмжээгээр бүрдсэн байна.

Эрдэмтэн судлаачид төрийн бодлого, хөтөлбөрүүд хангалттай түвшинд байгаа хэдий ч хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явц нь хангалтгүй байдаг, эсхүл дугуйлан секцэд ямар нэг байдлаар улсын төсвөөс дэмжлэг, санхүүжилт байдаггүй учраас тогтвортой, үр дүнтэй байлгах тал дээр хяналт тавихад нарийн төвөгтэй байж болох талтай гэж үзэж байна. Тэд дараах сэтгэгдлүүдийг хэлсэн байна.

*БХАН нь 2018 онд Дэлхийн банкны санхүүжилтээр, Нийслэлийн боловсролын газрын захиалгаар хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийсэн. Судалгааны эхний шатанд дээд газрын бодлого, зорилтууд ямар байгааг судлахад баримталж буй бодлого, хөтөлбөрт хүүхэд бие даасан, бүтээлчээр үйл ажиллагаанд оролцдог, бүтээлч сэтгэлгээтэй иргэн болж төлөвших талаар нэлээдгүй дурдсан байдаг. Энэхүү зорилтууд нь хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцэж буй эсэхийг тогтоохын тулд бид эхлээд хүүхдүүдээс судалгаа авсан. Судалгааны үр дүнд хүүхдийн хүсэл, сонирхол болон төрөөс баримталж буй зорилтууд хоорондоо нийцэж байсан. **Салбарын экспертийн ярилцлагаас***

*Одоогийн байдлаар сургуулиас гадуур сонгон, секц, дугуйлан хичээллүүлэх энэ чиглэлээр журмын төсөл бодлогын яамнаас боловсруулагдаж байна. Энэ журмын төсөлд хувьсах зардалд нь тохирсон тодорхой хураамж авахыг зөвшөөрөх ч гэдэг юмуу, тодорхой мэргэжлийн багш нарын сонгон, секц хичээллүүлсэн цагийг багшийн хичээл заасан цагт тооцох, тэр багшийн үндсэн багшаар ажиллуулах ч юмуу тодорхой чиглэлийн ажлуудыг тусгаад явж байгаа болохоор цаашдаа илүү боломж бий болохоор байна. Шинэ журмаар дугуйлан, сонгон, секцийг хичээлийн цагт тооцдог, тодорхой хэмжихүйц хэмжээний төлбөр хураамж авдаг болгоод ирэхээр сургууль өөрөө бие даасан санхүү, бие даасан бодлогоо аваад явах боломж бүрдэхээр байна. **Салбарын экспертийн ярилцлагаас***

2.3. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Ерөнхий боловсролын сургуулийн ХГҮА, дугуйлан, сонгон, секцийн нэр төрөл, чанар хүртээмж, нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд төдийлөн олон биш байна. Тайлангийн энэхүү хэсэгт өмнө хийгдсэн дараах судалгааны ажлын тоймыг онцлон авч үзэж орууллаа.

- 2013 онд Монгол улс Будапешт дэх Нээлттэй Нийгмийн хүрээлэнгээс санаачлан хэрэгжүүлсэн Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын хамрагдаж буй төлбөрт давтлага/дамжааны талаарх олон улсын судалгааг БХАН гүйцэтгэсэн байна. Энэхүү судалгааны ажлын зорилго нь төлбөртэй давтлага/дамжааны цар хүрээг үнэлэх, ерөнхий боловсрол, нийгэм, болон эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг олж мэдэх, эцэг эх, багш, сурагч болон бодлого боловсруулагчид нарын анхаарлыг энэ асуудал дээр хандуулах, төлбөртэй давтлага/дамжааны өсөж байгаа үр нөлөөнд хяналт тавихад холбогдох зөвлөмж гаргах, бодлого боловсруулах байсан. Судалгааны онцлох үр дүнгээс дурдахад төлбөртэй давтлага/дамжааны асуудал нь дэлхийн олон оронд байдгийн нэг адил асар том нуугдмал үйлдвэрлэл болтлоо өргөжсөнөөс гадна багшийн ёс зүй алдагдах, авлигад өртөх үндэс суурь болж, нийгмийн сэтгэл зүйд болон боловсролын чанарт хор хөнөөл учруулж болзошгүй байна хэмээжээ. Түүнчлэн зөвхөн шалгалтдаа сайн бэлдэх, өмнө үзсэн хичээл, сэдвүүдийг системтэйгээр ойлгох, сэргээн санах,

дунд сургуульд заагдсан хичээлүүдийг илүү сайн ойлгох, хоцорсон хичээлүүдээ ойлгож авах, эцэг эхийн санаачилгаар, бусдын жишгийг дагаж төлбөртэй давтлага/дамжаа-д хамрагддаг байжээ. Төлбөртэй давтлага/дамжаа-г дунд сургуулийн багш нар хамгийн ихээр заадаг бөгөөд олон цагийн төлбөртэй давтлагад (1,000₮ - 1,000,000₮) дунджаар **59,400 төгрөг**, төлбөртэй дамжаанд (500₮ - 400,000₮) дунджаар **33,000₮ төгрөг** төлсөн байна. Мөн судалгаанд оролцогчдын олонхын үнэлгээгээр ЕБС-ийн сургалтын чанар ихээхэн муудаж, сургалтын хөтөлбөрт заагдсан зүйлийг сурагчдад эзэмшүүлэх байдал хангалтгүй байна гэсэн дүгнэлт гарчээ. Төлбөртэй давтлага/дамжаагүйгээр сурагчдын эзэмшиж болох зүйлийг ч гэсэн эзэмшүүлэхгүй байгаа талаар судалгаанд оролцогчид шүүмжилсэн байна. Дээр дурдсан зүйлүүдээс харахад төлбөртэй давтлага/дамжаа бий болох үндэс суурь болсон ерөнхий боловсролын сургууль төгсөх шалгалт, их дээд сургууль, коллежийн элсэлтийн шалгалтын талаар баримтлах бодлого чиглэлийг судалгааны үндсэн дээр тогтоон хэрэгжүүлэх шаардлага боловсролын салбарын өмнө тулгамдсан асуудлуудын нэг болжээ. Түүнчлэн цаашид төлбөртэй давтлага/дамжааны эерэг сөрөг талыг нарийвчлан судлах шаардлагатай нь судалгаанаас харагдсан байна. Төлбөртэй давтлага/дамжаа нь сургалтын чанар доогуур байгааг харуулж байгаа бөгөөд, хот хөдөөгийн хүн амын хоорондын тэгш бус ялгаатай байдлыг улам ихэсгэж, дунд сургуулийн багш төлбөртэй давтлага өгч байгаагаараа тэдний ёс зүй, ёс суртахууны үнэт зүйлс алдагдаж байж болзошгүйг хөндсөн байна.

- 2018 онд Дэлхийн Банк, Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр БХАН нь “ЕБС-ийн дунд ангийн ХГҮА-д хийсэн хөндлөнгийн үнэлгээ” хэмээх судалгааг хийжээ. Энэхүү хөндлөнгийн үнэлгээний зорилго нь ЕБС-ийн дунд ангийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлээс гадуурхүйлажиллагааны эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн байдалд хөндлөнгийн үнэлгээ хийж чанар, хүртээмж, хэрэгцээнд нийцсэн байдлыг тодорхойлоход байсан. Судалгааны үр дүнд хөндлөнгийн үнэлгээний хүрээнд дэвшүүлсэн ЕБС-ийн дунд ангийн ХГҮА-ны төлөвлөлт, зохион байгуулалт, эзэмших чадварын төрийн зорилт, сургуулийн нийлүүлэлт, суралцагчийн эрэлт хоорондоо нийцэж байна уу? гэсэн асуултад хөндлөнгийн үнэлгээ хийсэн багийн зүгээс бүрэн нийцсэн, нийцсэн, хангалтгүй, нийцээгүй гэсэн үнэлгээний 4 түвшнээс ХАНГАЛТГҮЙ гэсэн үнэлгээг өгсөн байна. ”Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” ЗГ-ын 89-р тогтоолын үнэлгээний арга

зүйн хүрээнд авч үзвэл “эрчимжүүлэх шаардлагатай”- 40 хувь (31-59 хувь хүртэл) гэсэн ангилалд хамаарна хэмээн дүгнэжээ.

- 2018 онд ГБХЗХГ-аас “Өдөр өнжүүлэх төвүүдийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа”-г хийсэн байна. Судалгааны зорилго нь өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, өдөр өнжүүлэх төвүүдийн жишиг стандарт, магадлан итгэмжлэх тухай журам боловсруулах болон цаашид авах арга хэмжээнд шаардлагатай мэдээллийг цуглуулж, дүгнэлт гаргахад оршино. Судалгааны үр дүнд өдөр өнжүүлэх төвүүдийг ашигтай ажилладаг бизнесийн байгууллага бус хүүхдийн хөгжлийн хамгийн эхний суурь тавигддаг цэцэрлэгийн боловсролтой дүйх боловсролын салбарын нэг хэсэг хэмээн үзэн, төрийн бодлогын хэмжээнд эрх зүйн орчныг тодорхойлж өгөх шаардлагатай гэж үзэж дүгнэсэн байна.

Мөн тайланд тусгагдаагүй хэдий ч дараах судалгааны ажлууд хийгдсэн байна.

- “Насан туршийн боловсролын төвд дугуйлан, секц, клуб ажиллуулах зөвлөмж”, БСШУ. (2016)
- “Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн шаардлага”, БСШУЯ. (2016)
- “Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулж буй нөхцөл байдлын шинжилгээ”-ний тайлан Боловсролын хүрээлэн. (2017)

Өмнө хийгдсэн ижил төстэй судалгааны тайлангийн үр дүнгээс дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна.

1. ЕБС-ийн хичээлээс гадуур зохион байгуулагдаж буй сургалт, дамжаа, дугуйлангийн үйл ажиллагааны нэр төрөл, чанар, хүртээмж, үнэ төлбөрийн нөхцөл байдлыг тодорхойлсон судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл төдийлөн их байна. Гэвч сурагчид хичээлээс гадуурх үйл ажиллагаанд тодорхой хэмжээний төлбөр төлсөөр байна. Эндээс сурагчдад эрэлт, хэрэгцээ байна хэмээн хэлж болох бөгөөд цаашид судлах хэрэгцээ, шаардлага ч бас байсаар байгааг харуулж байна.
2. 2013 оны байдлаар сурагчид нэмэлтээр давтлага/дамжаанд хамрагдахгүй бол их, дээд сургуульд элсэн орж чадахгүй хэмээн үздэг бөгөөд ахлах ангийн сурагчдын дийлэнх нь хичээлийн холбогдолтой нэмэлт давтлага/дамжаа-д хамрагддаг байна.
3. ЕБС-ийн багш нар хичээлээс гадуур төлбөртэй давтлага явуулах нь ашиг сонирхлын зөрчил, авлига, сурагчдыг ар гэрийн амьдралаар нь ялгаварлан гадуурхах хандлагыг нэмэгдүүлж болох талтай гэж үзлээ.

4. Ерөнхийдөө судлагдсан бүтээлүүдэд хичээлээс гадуурх үйл ажиллагаа, сургалт, давтлага/дамжаа – ны зохион байгуулалт, үйл ажиллагаа, нэр төрөлд өгч байгаа үнэлгээ, дүгнэлтүүд хангалттай түвшинд сайн биш байна.

2.4. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГУУД

2.4.1 Олон улсын боловсролын үнэлгээний тухай

Дэлхийд сайн боловсролын чанар, хүртээмжийг үнэлдэг төрөл бүрийн байгууллагууд байдаг. Жишээлбэл, НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага буюу ЮНЕСКО, Европын холбооны дээд боловсролын чанарыг үнэлэх байгууллага – ENQA, Европын Зөвлөл буюу Council of Europe. Тэр дундаас бусад үнэлгээтэй харьцуулахад илүү олон орныг хамарсан, боловсролын үнэлгээг тууштай хийдэг нөлөө бүхий байгууллага бол Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) юм. Тус байгууллага нь жил бүр “Education at Glance”, 3 жил тутамд “Programme for International Student Assessment (PISA)” гэх тайлангуудыг гаргадаг.

A. “Education at Glance” үнэлгээний тайлан нь ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын боловсролын салбарын үйл ажиллагааг нарийвчлан судалдаг. Тус үнэлгээнд ЭЗХАХБ-ын бүх гишүүн болон хамтрагч орнуудыг хамруулдаг бөгөөд дараах мэдээллүүд багтдаг байна. Үүнд:

- Олон улс орны боловсролын салбарын онцлог шинж чанар, нөхцөл байдал
- Олон улс орны боловсролын салбарын ерөнхий үзүүлэлтүүд
- Сурагчдад зарцуулагддаг хөрөнгийн хэмжээ

B. “Programme for International Student Assessment (PISA)” үнэлгээний тайланд ЭЗХАХБ-ын орнуудын сурагчдын шинжлэх ухаан, уран зохиол болон математикийн хичээлүүдийн мэдлэгийг үнэлж, үүний үндсэн дээр тодорхой улсуудын сургалтын програм, боловсролын чанарыг ямар чиглэлээр шинэчлэх, сайжруулах шаардлагатай талаарх мэдээллээр хангадаг найдвартай эх үүсвэр юм. Энэхүү үнэлгээний тайлан нь тухайн улсын сурагчид юу мэддэгийг нь бус, мэдэж авсан зүйлсээрээ сургуульдаа, сургуулиас гадна юу хийж чаддаг болохыг нь харуулах зорилготой юм. Тус үнэлгээнд нийт 79 улсын 500,000 гаруй ЕБС-ийн сурагчид хамрагддаг бөгөөд тайландаа дараах дүгнэлтүүдийг тусгадаг. Үүнд:

- Сурагчдын ерөнхий мэдлэгийн түвшин
- Олон улсын ЕБС-ийн үйл ажиллагааны чиглэл болон үзүүлэлтүүд
- Олон улсын ерөнхий боловсролын програм болон баримталдаг стандартууд
- Олон улсын боловсролын бодлого, зорилго болон хэрэгжилт
- Ирээдүйд баримталбал зохих бодлого, төлөвлөгөө

Дээрх 2 үнэлгээний тайланг агуулгын хувьд харахад нэг нь илүү улс орны хэмжээнд болон бодлогын түвшинд үнэлгээг хийдэг бол нөгөөх нь сурагчдын мэдлэгийн түвшин, хүсэл сонирхол гэх мэт сурагч талаас нь судалдаг байна. Иймд судалгааны баг “Олон улсын сурагчдын боловсролын түвшингийн үнэлгээ (PISA)”-г ОУ-ын сайн туршлага бүхий, харьцуулалт хийх улс, орныг сонгоход ашиглахаар шийдлээ.

ЭЗХАХБ-ын боловсролын чанараар тэргүүлэгч улс орнууд

Сингапур, Хонконг, Япон, Макао зэрэг улс орны сурагчид боловсролын түвшингээр хамгийн өндөр оноо авч чадсан байна. Өөрөөр хэлбэл эдгээр улс орнууд ЭЗХАХБ-ын улс орнуудын боловсролын чансааг тогтоож буй хэрэг юм. Бидний сайн туршлагыг нь судлах улс орноо боловсролын түвшингээр тэргүүлэгч топ-10 улсаас сонгох болно.

Тус тайлан 2000 оноос эхлэн нийтлэгдэж эхэлсэн бөгөөд бусад улс, орнуудтай харьцуулахад Финланд, Өмнөд Солонгос улсууд нь боловсролын чанараараа хамгийн тогтвортой байж чадсан байна.

Хүснэгт 9. Дэлхийн боловсролын чанарын жагсаалт “Олон улсын сурагчдын боловсролын түвшингийн үнэлгээ”-ээр тэргүүлэгч Топ-10 улс

Д/д	Улсын нэр	Дундаж үзүүлэлт
1	Сингапур	551.7
2	Хонконг	532.7
3	Япон	528.7
4	Макао	527.3
5	Эстон	524.3
6	Канад	523.7
7	Тайван	523.7
8	Финланд	522.7
9	Өмнөд Солонгос	519.0
10	Хятад	514.3

Эх сурвалж: ЭЗХАХБ, 2015 оны PISA тайлан


ЕБС-ийн сургалтын программыг илүү үр өгөөжтэй байлгахын тулд сурагчдын сонирхол болон хэрэгцээг үл тоож болохгүй. Тиймээс сурагчдаас хичээл болон хичээлээс гадуур ямар төрлийн үйл ажиллагаанд оролцдог болохыг тус тайланд тусгадаг байна. Ихэнх орны сурагчид ШУ-ны холбогдолтой сургалт, дугуйлан, клубыг сонирхдог учраас энэ чиглэлд яг юу хийх сонирхолтой болохыг тайлбарлажээ.

ЭЗХАХБ-ын орнуудын нийт сурагчдын 23.0 хувь нь ШУ-ны тухай нэвтрүүлэг, интернэт орчноос мэдээлэл цуглуулах дуртай бол сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг сонирхох хувь нь харьцангуй бага буюу ердөө 8.3 хувь байдаг ажээ. Ихэнх улс, орнуудын сурагчид баримтат кино

болон нэвтрүүлгээр дамжуулж мэдээлэл цуглуулдаг нь хүртээмж болон зардал бага гардагтай холбоотой байна. Харин Финланд, Япон болон Нидерланд улсын сурагчдын сургуулиас гадуурх үйл ажиллагаанд оролцох идэвх бага байв. Үүний учир нь тус орнууд сургалтын программдаа нэмэлт дугуйланг зайлшгүй багтааж өгдөг бөгөөд сурагчид нь ч гэсэн заавал ядаж нэг дугуйлан, клуб сонгож явах шаардлагатай байдагтай холбоотой ажээ.

Харин Өмнөд Солонгос улсын сурагчдын ойролцоогоор 8.0 хувь нь ШУ-ны тухай баримтат кино, нэвтрүүлэг үздэг бол 13.0 хувь нь ШУ-ны клуб, секц, дугуйланг сонирхдог байна. Энэ нь ЭЗХАХБ-ын орнуудын дундаж үзүүлэлтээс дээгүүр байгаа юм.

График 2. Олон улсын сурагчдын шинжлэх ухааны холбогдолтой үйл ажиллагааны оролцоо, хувиар



Эх сурвалж: ЭЗХАХБ, 2015 оны PISA тайлан

ЭЗХАХБ-ын улс орнуудын санал болгодог сургуулиас гадуурх үйл ажиллагааны төрлүүд

Ихэнх сайн боловсрол олгодог улс, орнууд сургалтын хөтөлбөрийг илүү үр өгөөжтэй, сонирхолтой байлгах зорилгоор сурагчдадаа зөвхөн сургуулийн хүрээнд мэдлэг олгоод зогсохгүй, олон төрлийн сургуулиас гадуурх үйл ажиллагааг санал болгодог байна.

Сургуулиас гадуурх үйл ажиллагаа нь нэмэлт мэдлэг олгохоос гадна олон төрлийн ур чадварыг бий болгодог байна. Жишээ нь, харилцаа, бүтээлч байдал, бие даах байдал, багаар ажиллах гэх мэт амьдралд хэрэгцээт ур чадваруудыг бий болгодог байна.

ЭЗХАХБ-ын орнуудын сурагчдын 90 хувь нь спорт, 73 хувь нь сайн дурын ажил, 66 хувь нь шинжлэх ухааны тэмцээн болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг, 63 хувь нь урлаг болон уран зураг, 61 хувь нь дуу хөгжим, найрал дуу болон хөгжмийн хамтлаг, 58 хувь нь жүжиг болон мюзикл, 54 хувь нь сургуулийн сонин, хэвлэл мэдээллийн клуб, 39 хувь нь шинжлэх ухааны туршилтууд хийдэг клуб, 39 хувь нь компьютер, технологийн холбогдолтой клубыг сонирхдог бол 31 хувь нь шатрын клубыг сонирхож байна.

Хүснэгт 10. Олон улс орны сургуулиудын санал болгодог сургуулиас гадуурх үйл ажиллагааны төрлүүд

Тэмдэглэгээ	Сургуулиас гадуурх үйл ажиллагааны төрлүүд	Дундаж хувь
А	Хөгжмийн хамтлаг, найрал дууны клуб	61
Б	Жүжиг болон мюзиклын клуб	58
В	Сургуулийн сонин, сэтгүүлийн клуб	54
Г	Сайн дурын ажил	73
Д	Шинжлэх ухааны туршилт	39
Е	Шинжлэх ухааны тэмцээн	66
Ё	Шатрын клуб	31
Ж	Компьютер, технологийн холбогдолтой клуб	39
З	Урлагийн дугуйлан	63
И	Спортын клуб	90

Эх сурвалж: PISA 2015 оны тайлан, х.221

Дараах хүснэгтэд боловсролын чанараар тэргүүлэгч топ-10 улсын сурагчдын сургуулиас гадуурх хөтөлбөрт хамрагдаж буй хувийг харууллаа. Хүснэгтийн толгой болох А-И хүрсэн тэмдэглэгээ нь өмнөх хүснэгтийн тэмдэглэгээг илэрхийлж байгаа болно. Тухайлбал Хонконгийн сурагчдын 94 хувь нь хөгжмийн хамтлаг, найрал дууны клубт хамрагддаг бол тус улсын сурагчдын 91.6 хувь нь ямар нэгэн дугуйлан, сонгон, секц, клубд хамрагддаг байна.

Хүснэгт 11. Боловсролын чанараар тэргүүлэгч топ-10 улсын сурагчдын хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагддаг байдал, хувиар

Улс, орон	А	Б	В	Г	Д	Е	Ё	Ж	З	И	Дундаж хувь
Хонконг	94	81	91	100	95	87	75	95	98	100	91.6
Өмнөд Солонгос	86	55	85	100	93	86	95	84	97	99	88.0
Макао	94	95	95	100	74	96	42	79	97	100	87.2
Тайвань	92	60	97	99	80	81	71	76	95	99	85.0
Хятад	66	54	79	93	91	90	68	72	95	100	80.8
Сингапур	99	70	95	100	42	89	25	89	92	100	80.1
Канад	88	88	88	97	57	76	52	63	91	100	80.0
Япон	91	51	48	91	60	24	33	53	97	100	64.8
Эстони	81	50	57	76	42	94	21	46	75	96	63.8
Финланд	81	40	41	36	13	86	8	13	37	85	44.0


Эх сурвалж: ЭЗХАХБ, 2015 оны PISA тайлан

Дээрх хүснэгтээс топ-10 улсын сурагчдын сургуулиас гадуурх дугуйлан, сонгон, секц, клубийн үйл ажиллагаанд хамрагддаг байдлыг харж болохоор байна.

ЭЗХАХБ-ын улс орнуудын сурагчдын сургуулиас гадуурх үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа

Улс, орнуудын сургагчдын нэг долоо хоногт хичээлээс гадуурх үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа харилцан адилгүй байна. Боловсролын чанараар тэргүүлэгч топ-10 улсаас нэг долоо хоногт сургуулиас гадуурх үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа хамгийн их байгаа нь Хятад улс байна. Хамгийн бага хугацаа зарцуулж буй улс нь Финланд байна. Сурагчид ихэнх цагаа ШУ, математик, гадаад хэлний сонгон, дугуйлан, секцэд зарцуулж байна.

График 3. Боловсролын чанараар тэргүүлэгч топ-10 улсын сурагчдын нэг долоо хоногт хичээлээс гадуурх үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа, цагаар



Эх сурвалж: ЭЗХАХБ, 2015 оны PISA тайлан

ЭЗХАХБ-ын улс орнуудын боловсролын салбарт зарцуулагдаж буй хөрөнгийн хэмжээ

Энэ салбарт баримтлах бодлого, стратегийг тодорхойлох, төрөл бүрийн өөрчлөлт, шинэчлэлтийг хийх, сургуулийн болон сургуулиас гадуурх үйл ажиллагааг дэмжих, учирч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэхэд боловсролын салбарт зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээ чухал ач холбогдолтой байна.

Иймээс тухайн улс орон хэр их хэмжээний хөрөнгө оруулалтыг боловсролын салбарт хийдэг, тухайн хөрөнгө оруулалт, зардлууд хаашаа чиглэдэг, хэрхэн хуваарилагддагийг задалж үзэх нь чухал юм. Ерөнхий байдлаар боловсролын салбарын зардлуудыг дараах 3 төрөлд хуваадаг. Үүнд:

1. Улсын төсөв хаашаа чиглэж байгаагаар

Жишээлбэл, боловсролын салбарын төсвийн тодорхой хэмжээ ЕБС-ийн сургууль, их, дээд сургууль болон магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд руу чиглэдэг.

2. Улсын төсөв юунд зарцуулагдаж байгаагаар


Тус зардлуудад шинэ ном, бичиг хэргээр суралцагчдыг хангах, хүний нөөцийн зардал, сургуулийн иж бүрэн байдлыг хангах, суралцагчид болон багш нарыг хоолоор хангах, нийтийн тээврээр хангах, дотуур байраар хангах гэх мэт зүйлс багтдаг байна.

3. Улсын төсвийн эх үүсвэр

Тус санхүүжилтыг зөвхөн улсын төсвөөс бүрдүүлдэггүй ба олон улсын байгууллагууд ч хувь нэмрээ оруулах боломжтой байна.

ЕБС-аас их дээд сургууль хүртэл нэг суралцагчид ногдох зардлын хэмжээг дүрслэв. (Энд зөвхөн ЭЗХАХБ-ын орнуудыг тооцов) Доорх графикт харуулснаар Люксембург, АНУ, Австри, Норвеги зэрэг хөгжингүй улс, орнуудын хувьд нэг суралцагчид ногдох зардал хамгийн их буюу 20,000 ам. доллароос эхэлж байгаа юм. Харин дунджаар тооцох юм бол ЭЗХАХБ-ын орнууд ЕБС-аас эхлэн дээд сургууль хүртэл нэг суралцагчид 10,500 гаруй ам. доллар зарцуулдаг байна. Түүнчлэн боловсролын салбарт ногдох хөрөнгө оруулалтын хэмжээгээр сургалтын чанарыг хэмжих нь харьцангуй ойлголт юм. Жишээлбэл, АНУ-ын нэг сурагчид ногдох зардлын хэмжээг, Өмнөд Солонгос болон Финландтай харьцуулахад харилцан адилгүй байгаа бөгөөд аль аль нь дэлхийн шилдэг боловсрол олгодог улсуудаар тооцогддог.

График 4. ЕБС-аас дээд сургууль хүртэл нэг суралцагчид ногдох зардлын хэмжээ, мянган ам. доллароор



Эх сурвалж: ЭЗХАХБ, 2015 оны PISA тайлан

ЭЗХАХБ-ын улс, орнуудаас боловсролын чанараар тэргүүлэгч топ-10 улсыг сургуулиас гадуурх үйл ажиллагааны төрлүүдийн хамт өмнө нь тодорхойлсон билээ. Эдгээр 10 улсаас сайн туршлагатай байж чадахуйц 2 улсыг сонгоно гэдгийг дурдсан.

“Олон улсын сурагчдын боловсролын түвшингийн үнэлгээ”-ний тайланд тусгагдсан мэдээнээс харахад бусад улс, орнуудтай харьцуулахад Финланд, Өмнөд Солонгос улсууд нь боловсролын чанараараа хамгийн тогтвортой байж чадсан байна. Мөн сурагчдын сургуулиас гадуурх үйл ажиллагаанд хамрагдаж буй хувь, нэг долоо хоногт зарцуулж буй хугацаа, зарцуулж буй хөрөнгийн хэмжээ зэргийг харгалзан үзээд тус 2 улсыг сонгож авлаа.

Өмнөд Солонгос

Өмнөд Солонгос улсын боловсролын салбарын онцлох фактууд:

- Сурагчид дээд боловсролыг бусад ЭЗХАХБ-ын орнуудтай харьцуулахад илүү эрт эзэмшиж эхэлдэг.
- ЭЗХАХБ-ын орнуудын дундажтай харьцуулахад бүрэн дунд болон дээд боловсролыг бараг бүх иргэд эзэмшсэн байна.
- Бусад орнуудтай харьцуулахад боловсролын салбартаа нэлээдгүй их хөрөнгийг зарцуулдаг байна.
- Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн мэргэжлийн чиглэлүүд хамгийн эрэлттэй ажээ.

Өмнөд Солонгос улс нь ХХ зууны хоёрдугаар хагасаас эхлэн өөрийн боловсролын систем, бодлогыг тууштай шинэчилж, сайжруулсаар иржээ. Ийнхүү 1980-1990 оны хооронд Өмнөд Солонгос улс боловсролынхоо салбарыг дэлхийд гаргах, улам чанаржуулах зорилгоор дараах гол 4 чиглэлд анхаарч ажиллахаар болсон байна. Үүнд:

1. *Сургалтын системийг дэмжих Засгийн газрын санаачилга*

Энэ үе шатанд их, дээд сургуульд элсэх үйл явц болон тэдгээрт тавигдах шаардлагуудыг шинэчлэх, ЕБС-дыг шинэчлэх, сэргээн засах, олон улсын стандартад нийцүүлэх, өндөр түвшний, мэргэжлийн багш нараар хангах, шинжлэх ухааны боловсролыг чухалчлан авч үзэх, сургалтын програм болон аргачлалыг шинэчлэх, боловсролын салбарын хараат бус байдлыг дэмжих, урт, удаан чанартай боловсролын системийг бүтээх авсан байна.

2. *Сургалтын чанарыг сайжруулахад шаардлагатай хөрөнгө оруулалт татах*

Боловсролын салбарт нэмэлт санхүүжилт, хөрөнгө оруулалт татах нь маш чухал бөгөөд Өмнөд Солонгос улс тус төсвийн хэмжээг нэмснээр сургуулийн тоог нэмж, нэг ангид суралцах сурагчдын тоог багасган, багш нарын ажлын орон тоо болон цалинг нэмж чаджээ.

3. ***Мэдээлэл, харилцаа холбооны салбарт хөрөнгө оруулалт татах***

Ирээдүйд мэдээлэл, харилцаа холбооны хөгжил дэвшил нь цаашдын хөгжлийн хурдасгуур болно гэж үзэн тус салбарын дэвшлийг бүх нийтийн хүртээл болгох, хүний хөгжлийг дэмжих, олон нийтийг хэрэгцээт мэдээллээр хангах зорилгоор “Үндэсний нэгдсэн боловсролын мэдээллийн систем (NESI)”, “Мэдээллийн болон судалгааны нэгдсэн систем (KERIS)”-үүдийг нэвтрүүлсэн байна.


4. ***Дээд боловсролын сургалтын программыг шинэчлэх***

2000 оноос одоог хүртэл хийгдсээр байгаа шинэчлэлтүүдэд дараах зүйлд оршино. Үүнд:

- “Боловсролд чиглэсэн халамжийн мастер төлөвлөгөө (2008-2012)”- Бүгдэд эрх тэгш боловсрол эзэмших тогтолцоог бий болгоход чиглэгдсэн. Тус төлөвлөгөөний хүрээнд мэргэжлийн боловсрол олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, их дээд сургуулийн сургалтын програмыг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэх төслүүд хэрэгжсэн байна. Түүнчлэн 2012 оноос эхлэн ***5 настай хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрүүд идэвхтэй зохион байгуулагдсан байна.***
- Бүтээлч ур чадварыг бий болгох урлагийн сургуулиуд - ***Бүтээлч байдал болон хувь хүний хөгжлийг бий болгох нь*** боловсролын бодлогын чухал зүйлсийн нэг юм. Тиймээс сүүлийн жилүүдэд олон урлагийн сургуулиуд нээгдэж, сурагчдын хувь хүний хөгжил, бүтээлч талд илүү анхаарах болсон байна.
- Улсын сургуулиудыг дэмжиж ажиллах - Улсын сургуулиудын ***сургалтын чанарын түвшинг нэмэгдүүлснээр*** янз бүрийн нийгмийн давхаргын сурагчдад эрх тэгш боломжийг олгож байгаа юм. Ингэхийн тулд улсын ***сургуулиудад чиглэж буй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хувийн сургуулиудад тавих шаардлагуудыг өндөрсгөжээ.*** Үүнээс гадна 2006 оноос эхлэн “After School” системийг хэрэгжүүлж эхэлжээ.

Харин Өмнөд Солонгосын сурагчдын ерөнхий мэдлэгийн түвшинг харах юм бол “Олон улсын сурагчдын боловсролын түвшингийн үнэлгээ (PISA)”-ний тайланд тусгагдсанаар бусад улс орнуудтай харьцуулахад математик, шинжлэх ухааны хичээлүүд дээр маш өндөр үнэлгээ авч жагсаалтын дээгүүр бичигдэж байна.

График 5. “Олон улсын сурагчдын боловсролын түвшингийн үнэлгээ (PISA)” 2015 оны үзүүлэлт



Эх сурвалж: ЭЗХАХБ, 2015 оны PISA тайлан

Түүнээсгадна Өмнөд Солонгос улсын боловсролын салбарын амжилтын гол үндэс нь багш нар юм. Одоогийн байдлаар, Өмнөд Солонгост багш мэргэжил хамгийн алдартай, эрэлт ихтэй мэргэжлээр тооцогддог бөгөөд багш нарт тогтвортой ажлын байр, тааламжтай нөхцөл, өрсөлдөхүйц цалин амладаг байна.

Сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланд идэвхтэй оролцох нь сурагч, оюутнуудын хувийн менежмент, ирээдүйн ажлын байранд шаардагдах ур чадваруудыг эзэмшихэд маш их хувь нэмэртэй хэмээн үздэг байна.

Тухайлбал, мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ур чадварууд болох аналитик сэтгэлгээ, цагийн менежмент, ачаалал даах чадвар, багийн ажиллагаа зэрэг ур чадваруудыг олгох сургалтуудыг өргөжүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх зорилготой бодлого ихээхэн баримталдаг байна. Сургуулийн сурагчдын ерөнхий боловсролын программд компьютер, спорт, урлагийн хичээлүүдийг нэмж өгч илүү өргөн хүрээтэй болгосноор сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланд зарцуулагдах мөнгө, хугацааг хэмнэж өгөх боломжийг бий болгожээ.

Сеул хотын шилдэг олон улсын сургууль болох Ёонгсан Олон Улсын Сургууль нь (Yongsan International School of Seoul) Америкийн ерөнхий боловсролын программ дээр суурилсан бөгөөд өөрийн сурагчдадаа олон төрлийн сургалт, дамжаа, клуб, сонгон, секц, дугуйланг санал болгодог байна. Сурагчдын сонирхол, хэрэгцээн дээр суурилан дараах төрлүүдийг бий болгожээ.

Хүснэгт 12. Ёонгсан сургуулийн санал болгодог сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн төрлүүд

№	Дугуйлангийн нэр	Эзэмших ур чадварууд
1	Балет	Уян хатан байдал, тэсвэр тэвчээр, урлагийн өндөр мэдрэмж
2	Сагс	Биеийн чийрэг байдал, логик сэтгэлгээ
3	“Залуу найруулагч” клуб	Өөрийгөө илэрхийлэх, мотиваци, кино найруулах, бичлэг засварлах мэдлэг г.м.
4	Хөгжмийн дугуйлан	Хүссэн хөгжмийн зэмсэг дээр тоглож сурах боломж
5	Шатар	Логик сэтгэлгээ, шийдвэр гаргах
6	Сайн үйлсийн клуб	Дуртай зүйлсээ бүтээн хэрэгцээт хүмүүст бэлэглэх
7	Дизайн	Креатив сэтгэлгээ, зохион бүтээх
8	Жүжиг	Креатив сэтгэлгээ, хурдан дасан зохицох чадвар, багийн ажиллагаа
9	Математик, Хими	Ерөнхий мэдлэг сайжруулах, аналитик сэтгэлгээ, шийдвэр гаргалт
10	Нийгмийн этик	Олон нийтийн газар хэрхэн зөв биеэ авч явах, харилцааны чадвар, өөрийгөө зөв танилцуулах, ойлгуулах

Ерөнхий байдлаар ихэнх улсын сурагчид 3 төрлийн нэмэлт дугуйланг ихээр сонирхдог байна. Энэ нь урлаг, спорт болон шинжлэх ухааны дугуйлангууд юм. Сургуулиас гадуурх сургалт, дамжаануудыг сурагчдад сонирхолтой, үр дүнтэй байлгахын тулд улирал бүр өөрчилдөг.

Түүнчлэн Өмнөд Солонгосын сурагчдын 90 хувь нь ШУ-ны холбогдолтой клуб, дугуйлан, тэмцээн идэвхтэй зохион байгуулдаг сургуулийг сонирхож элсдэг байна. Сургалтын программдаа ийм төрлийн нэмэлт дугуйлангууд нэмснээр сурагчдынхаа хүсэл, сонирхлыг тодорхойлоход нь тусалж, тодорхой чиглэлийн хичээлүүдийг сурагчдад сонирхолтой болгодог. Өмнөд Солонгос улсын боловсролын системийн гол зарчим нь юу зааж байгаадаа бус юуг яаж, ямар аргачлалаар зааж байгаа нь чухал байдаг.

Финланд

ЭЗХАХБ-ын анхны “Олон улсын сурагчдын боловсролын түвшингийн үнэлгээ (PISA)” тайлан нийтлэгдсэнээс хойш өнөөг хүртэл Финланд улс боловсролын чанараар тэргүүлэгчдийн тоонд тооцогдсоор байна. Түүнчлэн Финланд улсын боловсролын системийн гол онцлог бол нийгэм, эдийн засгийн байдлыг нь харгалзан үзэж бүгдэд эрх тэгш боловсрол олгогдоороо алдартай.

Хүснэгт 13. Финланд улсын сурагчдын ерөнхий мэдлэгийн үзүүлэлтүүд

Хичээлийн нэр	PISA 2000	PISA 2003	PISA 2006	PISA 2009	PISA 2015
Уран Зохиол	546	543	547	536	526
Математик	-	544	548	541	511
Шинжлэх ухаан	-	-	563	554	531

Эх сурвалж: ЭЗХАХБ, 2015 оны PISA тайлан

Финланд улсын боловсролын салбарын онцлох фактууд:

- Финланд улс нь сурагчдадаа боловсрол олгоод зогсохгүй, түүнтэй холбоотой иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг юм. Жишээлбэл, бүх сурагчдыг өдрийн хоолоор хангах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлдэг. Энэ нь улсын хариуцлага гэж үздэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах асуудлыг чухалчлан авч үздэг. Ингэхийн тулд багш нарыг сургалтад хамруулж, мэргэжлийн ур чадвараар дэмждэг байна.
- Тус улсад нэгдсэн сургалтын программ байдаг боловч сурагчид өөрсдийн сонирхол, боломжид суурилан тусгай, хувийн сургалтын програмын дагуу суралцах боломжтой байдаг. ЕБС-ийн 10-12 дугаар ангиас эхлэн сурагчид өөрсдийн сонирхол, хэрэгцээний дагуу хувийн сургалтын программыг зохиох эрх нээгддэг. Ингэснээр сурагчдын бүтээлч, бие даасан байдлыг дэмжихийн зэрэгцээ урдаа зорилго тавин түүндээ хүрэх алхмуудыг тодорхойлж сурахад нь тусалдаг гэж үзжээ.

Дэлхийд үнэлэгдсэн боловсролын систем: Финланд улсын одоогийн нөхцөл байдал

2010 оны байдлаар тус улсын боловсролын түвшин олон улсын дундаж үзүүлэлтээс нэлээдгүй өндөр буюу 25-34 настнуудын 38 хувь нь дээд боловсролтой, 90 хувь нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн байгаа ажээ. Түүнчлэн бүх хүнд эрх тэгш боловсрол эзэмших боломж, бололцоог бүрдүүлж өгдөг бөгөөд үүнийг ч зайлшгүй баримтлах шаардлагатай зарчмуудын нэг гэж үздэг байна. Үүнээс гадна багш нарыг маш их үнэлж, хүндэлдэг ажээ. Харин багш мэргэжлийг эзэмших үйл явц нь тийм ч амар зүйл биш бөгөөд Хелсинкийн их сургуульд жилд 2,300 хүсэлт ирдэг ба нийт 20,000 хүнээс зөвхөн 5,000 элсэгчийг л сонгож сургадаг байна. Тус мэргэжлийг сонгох гол хүчин зүйл нь цалин бус нийгэмд эзлэх байр суурь, карьерийн уян хатан байдал, нийгэмд өөрийн хувь нэмрээ оруулах боломжийг бүрдүүлж байгаа нь чухал байдаг.

Боловсролын системийн гол онцлог нь сурагчдын ерөнхий мэдлэгийг үнэлэх зорилготой шалгалтуудыг олон удаа авах шаардлагагүй гэж үздэгт оршино. Учир дараах 2 шалтгаантай гэж үзлээ. Үүнд:

- *Ерөнхий мэдлэгийн үнэлгээ чухал ч гэсэн Финланд улсын ихэнх сургуулиуд сурагчдын сонирхол, хэрэгцээн дээр тулгуурлан тусгай сургалтын программыг зохиодог учир шалгалтын статистик тоон үзүүлэлт чухал бус мэдлэг, боловсрол эзэмшихийн зэрэгцээ тухайн хүний хувь хүний хөгжил, бүтээлч байдал чухал гэж үзжээ.*

- Шалгалт авах аргачлал болон түүний үр дүнд анхаарал хандуулахаас илүүтэйгээр хичээлийг хэрхэн үр дүнтэй заах аргачлал, сурагчид юуг өөрчилбөл цаашдаа илүү сайн сурах хандлагатай байна вэ, сурах явцыг сурагчдад сонирхолтой болгох тал дээр голчлон анхаарлаа хандуулжээ.

Боловсролын салбартаа хамгийн их хөрөнгө зарцуулдаг улсуудын нэг бөгөөд 2016 оны байдлаар ДНБ-ий 1.7 орчим хувийг их дээд боловсролын байгууллагуудад зарцуулсан байна. Хэрэв тоогоор илэрхийлэх юм бол их дээд сургуулийн нэг суралцагчид ногдох зардлын хэмжээ ойролцоогоор 17,500 ам.долларт хүрч байгаа юм. Энэ нь ЭЗХАХБ-ын орнуудын дундаж үзүүлэлтээс 2,000 гаруй ам.доллороор илүү болжээ.

Харин сургуулиас гадуурх нэмэлт дугуйлан, клубүүдийн тухайд аль болох уян хатан байдлыг эрхэмлэжээ. Тус улсад хичээлийн дараа явагддаг клуб, дугуйлангууд болон сургуулийн хүрээнд зохион байгуулагддаг клуб, дугуйлангууд гэж байдаг байна. Тус дугуйлангуудын мэдээллийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 14. Финланд улсын сургуулиас гадуурх үйл ажиллагааны төрлүүд

Хичээлийн дараа эхэлдэг дугуйлангууд (Afternoon Activities)		Сургуулийн хүрээнд зохион байгуулагддаг дугуйлангууд (School Club Activities)
4 цагийн клуб 5 цагийн клуб	Бага ангийн сурагчдад заавал явах шаардлагатай нэмэлт, дугуйлангууд байдаггүй бөгөөд тэдэнд хичээл бүрийн дараа 5-10 минут гадаа тоглоомын талбайд тоглох боломж өгдөг байна	Хувь хүний хөгжил, танин мэдэхүйн воркшоп
	Харин дунд ангийн сурагчид бие бялдарт болоод сэтгэл санаа, бүтээлч байдалд нь илүү анхааран нэмэлт спортын дугуйлан, гар урлалын клуб, зургийн дугуйлан гэх мэт олон төрлийн дугуйлангуудыг зохион байгуулдаг байна.	Урлагийн клубүүд

Нэмэлт дугуйлан, клубүүдийн төрлүүд тухайн сургуулийн сургалтын төлөвлөгөө, сурагчдын сонирхлоос хамааран өөрчлөгдөж байдаг учир дээрх хүснэгтэд зөвхөн ерөнхий мэдээллийг тусгалаа. Харин төлбөрийн хувьд 4 цагийн клуб нь ойролцоогоор сард 80 гаруй еврогийн үнэтэй харин 5 цагийн клуб нь 110 еврогийн үнэтэй байдаг байна.

2.4.2. Харьцуулалт

Тайлангийн энэхүү хэсэгт өмнө судлагдсан судалгааны үр дүнг нэгтгэсэн гол үзүүлэлтүүдийг харьцууллаа.

Сонгон авсан Өмнөд, Солонгос, Финланд улсууд нь боловсролын чанараар тэргүүлэгчдийн тоонд зүй ёсоор бичигддэг байна.

Сурагчдын сургуулиас гадуурх үйл ажиллагаанд 1 долоо хоногт зарцуулж буй хугацаа ЭЗХАХБ-ын орнуудын дунджаар 15.2 цаг байдаг бол Өмнөд Солонгос улсад 17.2, Финланд улсад 10.0 цаг байна. Харин боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалтын хувьд аль аль нь ЭЗХАХБ-ын дунджаас дээгүүр байна. Эндээс боловсролын салбарт хийх хөрөнгө оруулалтын хэмжээ маш чухал болох нь харагдаж байна.

Хүснэгт 15. Өмнөд Солонгос болон Финланд улсын ерөнхий үзүүлэлтүүдийн харьцуулалт

№	Нэр	Боловсролын түвшний үнэлгээ	Зарцуулж буй хугацаа, 1 долоо хоногт зарцуулах цагаар	Боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалт, мянган доллароор
1	Солонгос	519.0	17.2	11.8
2	Финланд	522.7	10.0	10.0
3	PISA, дундаж	492.0	15.2	9.3

ЭЗХАХБ-ын орнуудын сурагчдын дийлэнх нь спорт, урлаг, ШУ, сайн дурын ажил хийх дугуйлан клубд хамрагдаж байна. Харин Өмнөд Солонгос, Финланд улсын сурагчид ч мөн адил дээрх чиглэлийн дугуйлан, клубд хамрагдах сонирхолтой байна. Зарим нэр төрлийн хувьд харилцан адилгүй байгаа нь тухайн улсын уламжлал, ёс заншилтай холбоотой байж болох юм.

Хүснэгт 16. Сургуулиас гадуурх хамрагддаг үйл ажиллагааны харьцуулалт, хувиар

Сургуулиас гадуурх үйл ажиллагааны төрлүүд	Дундаж хувь	Солонгос	Финланд
Хөгжмийн хамтлаг, найрал дууны клуб	61	86	81
Жүжиг болон мюзиклийн клуб	58	55	40
Сургуулийн сонин, сэтгүүлийн клуб	54	85	41
Сайн дурын ажил	73	100	36
Шинжлэх ухааны туршилт	39	93	13
Шинжлэх ухааны тэмцээн	66	86	86
Шатрын клуб	31	95	8
Компьютер, технологийн холбогдолтой клуб	39	84	13
Урлагийн дугуйлан	63	97	37
Спортын клуб	90	99	85
Дундаж	57	88	44

Судлагдсан 2 улсад нийтлэгээр ажиглагдсан зүйл нь багшийн мэргэжил тус улсуудад маш нэр хүндтэйд тооцогддог. Уг мэргэжилтнийг маш чанартай, бэлтгэдэг байна. мөн багш нарыг ур чадвар, арга, аргачлалаар дэмжих сайжруулах ажлууд хийгдсээр иржээ.

Тус 2 улсын боловсролын салбар хамгийн амжилттай яваа гол онцлог нь сурагчдын хэрэгцээ, шаардлагыг бүрэн судалж, танин мэдсэний үндсэн дээр хичээлийнхээ хөтөлбөрт тусгаж өгдөг. Хичээлийн арга, аргачлал, бусад материаллаг хэрэгцээг бүрэн шийдсэн байна. Энэ нь боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалттай холбоотой гэж үзлээ.

Хүснэгт 17. Харьцуулалт

Өмнөд Солонгос	Финланд
<ul style="list-style-type: none"> • Бүгдэд эрх тэгш боловсрол эзэмших тогтолцоог бий болгох бодлоготой. • 5 настай хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрүүд идэвхтэй зохион байгуулагддаг. • Бүтээлч байдал болон хувь хүний хөгжлийг бий болгох нь боловсролын бодлогын чухал зүйлсийн нэг юм. Тиймээс сүүлийн жилүүдэд олон урлагийн сургуулиуд нээгдэж, сурагчдын хувь хүний хөгжил, бүтээлч талд илүү анхаарах болсон байна. • Улсын сургуулиудын сургалтын чанарын түвшинг нэмэгдүүлснээр янз бүрийн нийгмийн давхаргын сурагчдад эрх тэгш боломжийг олгож байгаа юм. Ингэхийн тулд улсын сургуулиудад чиглэж буй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хувийн сургуулиудад тавих шаардлагуудыг өндөрсгөжээ. • Мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ур чадварууд болох аналитик сэтгэлгээ, цагийн менежмент, ачаалал даах чадвар, багийн ажиллагаа зэрэг ур чадваруудыг олгох сургалтуудыг өргөжүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх зорилготой бодлого ихээхэн баримталдаг байна. Сургуулийн сурагчдын ерөнхий боловсролын программд компьютер, спорт, урлагийн хичээлүүдийг нэмж өгч илүү өргөн хүрээтэй болгосноор сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланд зарцуулагдах мөнгө, хугацааг хэмнэж өгөх боломжийг бий болгожээ. • Өмнөд Солонгос улсын боловсролын системийн гол зарчим нь юу зааж байгаадаа бус юуг яаж, ямар аргачлалаар зааж байгаа нь чухал байдаг. 	<ul style="list-style-type: none"> • Финланд улс нь сурагчдадаа боловсрол олгоод зогсохгүй, түүнтэй холбоотой иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг. • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах асуудлыг чухалчлан авч үздэг. • Тус улсад нэгдсэн сургалтын программ байдаг боловч сурагчид өөрсдийн сонирхол, боломжид суурилан тусгай, хувийн сургалтын программын дагуу суралцах боломжтой байдаг. Ингэснээр сурагчдын бүтээлч, бие даасан байдлыг дэмжихийн зэрэгцээ урдаа зорилго тавин түүндээ хүрэх алхмуудыг тодорхойлж сурахад нь тусалдаг гэж үзжээ. • Сургуулиуд сурагчдын сонирхол, хэрэгцээнд тулгуурлан тусгай сургалтын программыг зохиодог учир боловсрол эзэмшихийн зэрэгцээ тухайн хүний хувь хүний хөгжил, бүтээлч байдлыг хөгжүүлэх нь чухал гэж үзжээ. • Шалгалтын үр дүнд анхаарал хандуулахаас илүүтэйгээр хичээлийг хэрхэн үр дүнтэй заах, сурагчид юуг өөрчилбөл цаашдаа илүү сайн сурах хандлагатай байна вэ, сурах явцыг сурагчдад сонирхолтой болгох тал дээр голчлон анхаарлаа хандуулдаг. • Сургуулиас гадуурх нэмэлт дугуйлан, клубүүдийн тухайд аль болох уян хатан байдлыг эрхэмлэдэг. Тус улсад хичээлийн дараа явагддаг клуб, дугуйлангууд болон сургуулийн хүрээнд зохион байгуулагддаг клуб, дугуйлангууд гэж байдаг байна. • Нэмэлт дугуйлан, клубүүдийн төрлүүд тухайн сургуулийн сургалтын төлөвлөгөө, сурагчдын сонирхлоос хамааран өөрчлөгдөж байдаг. Харин төлбөрийн хувьд 4 цагийн клуб нь ойролцоогоор сард 80 гаруй еврогийн үнэтэй.

БҮЛЭГ 3: СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ бүлэгт судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн нэр төрөл, сургалтын чанар хүртээмж, үнэ төлбөрийн нөхцөл байдал, олон улсын сайн туршлагын хэсгийг багтаалаа.

3.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд Булган, Ховд, Хэнтий, Төв аймгууд болон Улаанбаатар хотын ЕБС-ийн сурагчид хамрагдсан юм. Хүйсээр нь авч үзвэл нийт судалгаанд хамрагдсан сурагчдын 47.9 хувь нь эрэгтэй, 52.1 хувь нь эмэгтэй сурагчид байсан. Мөн судалгаанд хамрагдсан сурагчдын 32.0 хувь нь ахлах анги, 39.0 хувь нь дунд анги, 28.0 хувь нь бага ангийн сурагчид байлаа.

Байршлаар нь авч үзвэл 14.6 хувь нь Ховд, 13.3 хувь нь Булган, 14.4 хувь нь Төв, 15.4 хувь нь Хэнтий аймгаас хамрагдсан бол 42.3 хувь нь Улаанбаатар хотоос хамрагджээ. Түүврийн хуваарилалтыг жигд тархаасан нь судалгааны үр дүн бодит болох, харьцуулалт хийх боломжийг нэмэгдүүлэх давуу талыг бий болгосон хэмээн үзэж байна.

Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 51.8 хувь нь сургууль дээрээ, 48.2 хувь нь сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвд ямар нэгэн сонгон, секц, дугуйланд хичээллэдэг байна.

Хүснэгт 18. Судалгаанд хамрагдсан сурагчдын ерөнхий мэдээлэл

ДД	Ангилал	Үзүүлэлт	Давтамж	Хувь
		Нийт	390	100.0%
1	Хүйсээр	Эрэгтэй	187	47.9%
		Эмэгтэй	203	52.1%
2	Анги, бүлгээр	Ахлах анги	126	32.0%
		Дунд анги	154	39.0%
3	Аймаг, хотоор	Ахлах анги	110	28.0%
		Ховд аймаг	57	14.6%
		Булган аймаг	52	13.3%
		Төв аймаг	56	14.4%
		Хэнтий аймаг	60	15.4%
		Улаанбаатар хот	165	42.3%
4	Дугуйлангийн байршил	Сургууль дээрээ	202	51.8%
		Сургуулиас гадуурх сургалт, хөгжлийн төвд	188	48.2%
5	Сум, дүүргээр	Ховд (Жаргалант)	33	8.5%
		Буянт	24	6.2%
		Булган	37	9.5%

	Орхон	15	3.8%
	Зуунмод	30	7.7%
	Батсүмбэр	26	6.7%
	Хэрлэн	36	9.2%
	Өмнөдэлгэр	24	6.2%
	Баянзүрх	29	7.4%
	Сүхбаатар	88	22.6%
	Баянгол	27	6.9%
	Багануур	21	5.4%

3.2. СУРГУУЛИАС ГАДУУРХ СОНГОН, СЕКЦ, ДУГУЙЛАНГИЙН НЭР ТӨРӨЛ, ҮНЭ ТӨЛБӨР

3.2.1. Үйл ажиллагаа, нэр төрөл

Тайлангийн энэ хэсэгт сурагчдын хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн нэр төрөл, үнэ төлбөрийн мэдээллийг харуулна. Нэр төрлийг 13 бүлэг болгон ангилсан бөгөөд тухайн ангилалд чухам ямар төрлүүдийг багтаасныг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 19. Дугуйлан, сонгон, секцийн ангилал

№	Дугуйлан, сонгон, секцийн нэр төрөл	Тайлбар
1	Спорт	Бокс, үндэсний бөх, гар бөмбөг, жудо, сагсан бөмбөг, таеквондо, теннис, хийн буудлага, хоккей, хөл бөмбөг, хөнгөн атлетик, хүндийн өргөлт, усан сэлэлт, чөлөөт бөх, туялзуур сэлэм, гандболл, гимнастик
2	Шатар, даам	Шатар, даам
3	Хөгжим	Ятга, хийл, укулэлэ, төгөлдөр хуур, морин хуур, гитар, бишгүүр, шанз
4	Гадаад хэл	Хятад хэл, англи хэл, франц хэл, герман хэл, япон хэл, солонгос хэл
5	Хичээлтэй холбогдолтой нэмэлт давтлага	Физик, монгол хэл, математик, биологи, уран зохиол, хими
6	Бүжиг	Цэнгээнт бүжиг, ардын бүжиг, чөлөөт бүжиг
7	Гар урлал	Уран бичлэг, хатгамал, хайчилбар, сийлбэр, цаасан урлал, уран баримал, сүрлэн наамал, арьсан эдлэл урлал, монгол хувцас урлал, хүүхэлдэй
8	Дуу	Найрал дуу, хөөмий, ардын дуу, гоцлол дуу
9	Уран зураг	Уран зураг, дүрслэх урлаг
10	Хувь хүний хөгжил	Сайн дурын клубүүд, санхүүгийн боловсрол, мэтгэлцээн, иог, скаут, илтгэх урлаг, загвар, драм
11	Сэтгэн бодох чадвар	IQ, сампин
12	Зохион бүтээх хөдөлмөр	Нисэх загвар, ШУ, технологи
13	Бусад	Уран уншлага, уран нугаралт, яруу найраг

Судалгаанд нийт хамрагдсан сурагчдын 51.8 хувь нь буюу 202 сурагч сургууль дээрээ сүүлийн 1 жилийн дотор дугуйлан, сонгон, секцэд хамрагдсан байна. Үүнийг дугуйлан, сонгон, секцийн ангиллаар задлан дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 20. Сүүлийн 1 жилийн хугацаанд сурагчдын дугуйлан, сонгон, секцэд хамрагдсан байршил


№	Дугуйлан, сонгон, секцийн нэр төрөл	Сургууль дээрээ	Сургуулиас гадуурх сургалт, хөгжлийн төвд	Нийт
1	Спорт	121	110	231
2	Шатар, даам	22	14	36
3	Хөгжим	26	25	51
4	Гадаад хэл	17	34	51
5	Хичээлтэй холбогдолтой нэмэлт давтлага	48	25	73
6	Бүжиг	31	26	57
7	Гар урлал	4	19	23
8	Дуу	6	13	19
9	Уран зураг	5	5	10
10	Хувь хүний хөгжил	8	11	19
11	Сэтгэн бодох чадвар	19	5	24
12	Зохион бүтээх хөдөлмөр	9	2	11
13	Бусад	2	2	4
	Нийт	202	188	390

Өнөөгийн байдлаар сургууль дээр сагсан бөмбөг, гар бөмбөг, найрал дуу, хөгжмийн дугуйлангууд нийтлэг байдлаар хичээллэж байна. Сургууль дээр зохион байгуулагдаж буй дугуйлан, сонгон, секцүүдээс спортын төрөлд хамгийн их хамрагддагийг багш нарын зүгээс дурджээ. Энэ нь хүүхдүүдийн бусад чиглэлд хөгжих боломжийг хязгаарлагдаж болох талтай хэмээн үзэж байна. Үүнийг шийдэхийн тулд төрийн зүгээс ядаж анги, танхимын хүрэлцээг нэмэх тал дээр анхаарах хэрэгтэй гэв.

Сурагчид хамгийн их хамрагддаг дугуйлан, сонгон, секц нь спорт, дуу хөгжим, урлагийн төрөл байна. Энэхүү үзүүлэлт нь дэлхийд боловсролын чанараар тэргүүлэгч улс, орнуудын сурагчид спортын клубүүдэд хамгийн их хамрагддаг байсантай төстэй байна.

Дараах графикт сурагчдын сүүлийн 1 жилийн хугацаанд хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцүүдийг харууллаа.


Зураг 5. Сурагчдын сүүлийн 1 жилийн хугацаанд хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцүүд



Судалгаанд хамрагдсан сурагчдын 59.2 хувь нь спортын, 18.7 хувь нь хичээлийн холбогдолтой нэмэлт давтлага, 14.6 хувь нь бүжиг, 13.1 хувь нь гадаад хэл, мөн 13.1 хувь нь хөгжим, 9.2 хувь нь шатар, даам, 6.2 хувь нь сэтгэн бодох чадвар, 5.9 хувь нь гар урлал, 4.9 хувь нь хувь хүний хөгжил, 4.9 хувь нь дуу, 2.8 хувь нь зохион бүтээх хөдөлмөр, 2.6 хувь нь уран зураг, 1.0 хувь нь бусад нэр төрлийн дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж байна.

Сурагчдын дугуйлан, сонгон, секцэд хамрагдах байдал нь тэдний хүйсийн онцлогоос төдийлөн хамаарахгүй байгаа боловч ихэнх нэр төрөлд охид хамрагдах нь илүү байна.

График 6. Дугуйлан, сонгон, секцэд хамрагдах байдал, хүйсийн харьцаагаар




Тухайлбал бүжиг, дуу, хөгжим, гадаад хэлний дугуйлан, сонгон, секцэд охид илүү хамрагддаг бол спортын төрөлд хөвгүүд илүү хамрагдаж байгааг дээрх графикаас харах боломжтой.

Орон нутаг болон Улаанбаатар хотын сурагчдын дугуйлан, сонгон, секцэд хамрагдах байдал ерөнхийдөө ойролцоо байгаа боловч хэд хэдэн


үзүүлэлтийн хувьд онцлон дурдах шаардлагатай байна. Тодруулбал Улаанбаатар сурагчдын 16.4 хувь нь, орон нутгийн сурагчдын 10.7 хувь нь гадаад хэлний дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж байна. Энэ нь Улаанбаатар хотын сурагчдын гадаад хэлийг сурах хүсэл, сонирхол, нөөц боломж орон нутгийн сурагчдаас тодорхой түвшинд илүү байгааг илэрхийлж байна. Түүнчлэн гар урлал, хувь хүний хөгжлийн сургалтуудад Улаанбаатар хотын сурагчид орон нутгийн сурагчдаас түлхүү хамрагддаг байна.

График 7. Улаанбаатар хотын сурагчдын дугуйлан, сонгон, секцэд хамрагдах байдал, нэр төрлөөр



Орон нутгийн сурагчдыг дээрх нэр дурдсан чиглэлд хөгжих сонирхолгүй, идэвх сул хэмээн дүгнэж болохгүй бөгөөд техник хангамж, орчин нөхцөл гэх мэт хүчин зүйлсээс шалтгаалж болохыг анхаарч үзэх хэрэгтэй юм.

График 8. Орон нутгийн сурагчдын дугуйлан, сонгон, секцэд хамрагдах байдал, нэр төрлөөр



Сурагчид дугуйлан, сонгон, секцэд хамрагдахдаа сургууль дээрээ болон сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвд хичээллэж байгаа бөгөөд аль алинд нь ижил түвшинд хамрагдаж байна.

3.2.2. Үнэ төлбөр

Дугуйлан, сонгон, секцийг төлбөргүй болгоё гэвэл төр- хүүхдээ хөгжүүлэх сонирхол, зарцуулах хөрөнгө, мөнгийг шийдсэн цагт л ийм нөхцөл хангагдана. Өөрийн хүүхдийн давуу тал, гоц авьяасыг хөгжүүлэх эцэг эхийн хэрэгцээг сургуулиуд хангах хэмжээний сургалтуудыг төрөлжүүлж хөгжүүлэхэд төрийн маш том, цэгцтэй бодлого үгүйлэгдэж байна. Төрөөс нэг багшид ноогдох хүүхдийн тоог цөөлөх, сургууль дээр 1 ээлжээр хичээллүүлдэг болгох, багшид хичээлээс гадуурх сонгоны цагийн цалинг олгодог болгох, анги танхим, материаллаг баазаар хангадаг болох зэрэг бодлогын шинж чанартай алхмуудыг хийх хэрэгтэй гэж мэргэжилтнүүд үзэж байна.


Багш нарын зүгээс төлбөртэй байснаараа нэг талдаа чанарыг харуулна. Мөн багшийн хөдөлмөрийг үнэлэх нэг чухал хэрэгсэл болно хэмээн үзэж байна.

*Сургуулийн зүгээс бол багш нартаа өгөх урамшуулал байдаггүй тиймээс багш зохицуулах цаг дээрээ зарим нь дугуйлангаа ордог зарим нь давтлагаа ордог Энэ цаг нь 7 хоногт хоёр удаа ордог учраас давтамж нь бага тул үр дүн бол хир байх нь ойлгомжтой ер нь бол эдийн засгийн ямар нэгэн хөшүүрэг хэрэгтэй байна. **Багш нарын төлөөлөл***

Судалгаанд сүүлийн 1 жилийн хугацаанд хамрагдсан дугуйлан, сонгон, секц нь ямар нэгэн төлбөртэй байсан эсэхийг тодруулахад 42.1 хувь нь буюу 164 сурагч тийм, 57.9 хувь нь үгүй хэмээн хариулжээ. Өөрөөр хэлбэл 10 сурагч тутмын 4 нь хичээлээс гадуур хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцэд хамрагдахдаа ямар нэгэн төлбөр төлж байна.

Төлбөр төлөн суралцаж буй сурагчдын 73.0 хувь нь сургуулиас гадуурх ямар нэгэн сургалт хөгжлийн төвд төлбөр төлдөг байна. **Сурагчид сургууль дээр зохион байгуулагдаж буй дугуйлан, сонгон, секцэд хамрагдахдаа сард дунджаар 29,863 төгрөгийн төлбөр төлж байгаа бол бусад сургалт хөгжлийн төвд суралцахдаа дунджаар 74,843 төгрөг** төлдөг байна.

График 9. Төлбөртэй дугуйлан, сонгон, секцийн 1 сарын үнэ, төгрөгөөр



Төлбөр төлж суралцаж буй сурагчдаас 1 сарын сургалтын төлбөрийг тодруулахад гадаад хэлний төлбөр хамгийн их буюу дунджаар 176,913 төгрөг байлаа. Сурагчдын хамгийн их хамрагдаж буй спортын дугуйлан, сонгон, секцийн төлбөр дунджаар 37,225 төгрөг байгаа бол хамгийн бага төлбөртэй дугуйлан, сонгон, секцэд зохион бүтээх хөдөлмөр, гар урлал, бусад нэр төрлийнх багтаж байна.

Дугуйлан, сонгон, секцийн дундаж төлбөрийг байршлын хувьд задлан харвал Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт 79,166 төгрөг, Сүхбаатар дүүрэгт 72,340 төгрөг, Баянгол дүүрэгт 88,333 төгрөг, Багануур дүүрэгт 57,976 төгрөг байна.

Хүснэгт 21. Дугуйлан, сонгон, секцийн төлбөр, байршлаар

№	Байршил	Дундаж үнэ
1	Ховд (Жаргалант)	54,011
2	Буянт	39,000
3	Булган	25,000
4	Орхон	-
5	Зуунмод	52,286
6	Батсүмбэр	26,375
7	Хэрлэн	49,708
8	Өмнөдэлгэр	-
9	Баянзүрх	79,166
10	Сүхбаатар	72,340
11	Баянгол	88,333
12	Багануур	57,976

Харин энэхүү үзүүлэлтийг орон нутгийн хувьд задлан харахад Ховд аймгийн төвд 54,011 төгрөг, Булган аймгийн төвд 25,000 төгрөг, Хэнтий аймгийн төвд 49,708 төгрөг, Төв аймгийн төвд 52,286 төгрөг байна. Сумдын тухайд Булган аймгийн Орхон, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумдад ямар нэгэн төлбөртэй дугуйлан хичээллэдэггүй бол Ховд аймгийн Буянт суманд 39,000 төгрөг, Төв аймгийн Батсүмбэр суманд 26,375 төгрөг байна. Сумдад спорт, дуу, хөгжим, бүжгийн дугуйлан ихэвчлэн хичээллэдэг ажээ.

3.3. СУРГУУЛИАС ГАДУУРХ СОНГОН, СЕКЦ, ДУГУЙЛАНГИЙН ЧАНАР ХҮРТЭЭМЖ

3.3.1. Сэтгэл ханамжтай байдал

Эцэг, эхчүүд хүүхдийнхээ хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн чанар хүртээмжид маш их сэтгэл ханамжтай байдаг. Тэдний хувьд хүүхдийн өөрийнх нь хүсэл сонирхлыг харгалзан үзэж хамруулдаг учраас тухайн хамрагдаж буй чиглэлд хүүхэд нь ахиц дэвшил гаргаж, зөв бие хүн болон төлөвшиж байгаа нь сэтгэл ханамжтай байх гол шалтгаан нь болж байна.


Сурагчдын сэтгэл ханамжийн түвшнийг хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцээр нь харьцуулан дараах хүснэгтэд харууллаа. Хүснэгтээс харахад одоогийн байдлаар сурагчдад хамгийн их таалагддаг дугуйлан, сонгон, секц нь спортын төрөл байна.

Хүснэгт 22. Сурагчдын сэтгэл ханамжийн түвшин, нэр төрлөөр

Дугуйлан, сонгон, секцийн нэр төрөл	Таалагддаггүй	Дунд зэрэг	Таалагддаг	Маш их таалагддаг	Нийт
Спорт	5	3	104	119	231
Шатар, даам	-	-	23	13	36
Хөгжим	-	1	22	28	51
Гадаад хэл	1	1	18	31	51
Хичээлтэй холбогдолтой нэмэлт давтлага	-	-	28	45	73
Бүжиг	1	4	27	25	57
Гар урлал	-	-	4	19	23
Дуу	1	-	6	12	19
Уран зураг	-	-	5	5	10
Хувь хүний хөгжил	1	-	3	15	19
Сэтгэн бодох чадвар	-	5	12	7	24
Зохион бүтээх хөдөлмөр	-	-	2	9	11
Бусад	-	-	2	2	4
Нийт	4	11	170	205	390


Судалгаанд хамрагдсан сурагчдын 52.6 хувьд нь буюу 206 сурагчид одоогийн суралцаж буй дугуйлан, сонгон, секц маш их таалагддаг, 43.6 хувь буюу 170 сурагчид таалагддаг, 2.8 хувь 11 сурагчид дунд зэрэг санагддаг, 1.0 хувь буюу 4 сурагчид таалагддаггүй хэмээжээ. Огт таалагддаггүй хэмээн хариулсан сурагч байгаагүй. Дараах графикт сурагчдын сэтгэл ханамжийн хувийг харууллаа.

График 10. Сурагчдын сэтгэл ханамж, хувиар




Маш таалагддаг сурагчдын 43.4 хувь буюу 89 нь хөвгүүд, үлдсэн 56.6 хувь буюу 116 нь охид байна. Таалагддаггүй хэмээн 4 сурагч хариулсан бөгөөд үүний 3 нь охид байлаа.

График 11. Сурагчдын сэтгэл ханамж, хүйсийн харьцаагаар




Сургууль дээрээ дугуйлан, сонгон, секцэд хамрагддаг сурагчдын 48.5 хувь нь маш их сэтгэл ханамжтай байгаа бол сургуулиас гадуурх сургалт, хөгжлийн төвд хамрагдаж буй сурагчдын 56.9 хувь нь маш их сэтгэл ханамжтай байна.

График 12. Сурагчдын сэтгэл ханамж, дугуйлан, сонгон, секцийн байршлаар



Харин маш их таалагддаг хэмээн хариулсан нийт сурагчдын 52.2 хувь нь сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвд хамрагддаг сурагчид байлаа.

График 13. Сурагчдын сэтгэл ханамжийн түвшин



Гэвч сурагчдын сэтгэл ханамжтай, ханамжгүй байх нь тэдний хүйсийн харьцаа, дугуйлан, сонгон, секцийн төлбөр, амьдарч буй газар зэргээс төдийлөн хамаарахгүй байна.

Харин сэтгэл ханамж бага буюу таалагддаггүй хэмээн хариулсан сурагчид багш нь сонирхолгүй байдлаар хичээлийг заадаг, өөрөө сонирхдоггүй хэмээх шалтгаануудыг дурдсан байна.

3.3.2. Хэрэгцээ, шаардлагыг хангасан байдал

Дугуйлан, сонгон, секц хичээллүүлж буй удирдлагын хувьд багш хувиараа хичээллүүлж байгаа сургалт, сонгонууд бол харьцангуй чанартай явагддаг гэж боддог байна. Учир нь тэнд тодорхой хэмжээний төлбөр авдаг, тэр утгаараа аль аль талдаа хариуцлагатай байдаг. Үр дүнтэй болгохын тулд дугуйлангийн сурагчдынхаа нас, насны онцлогт тааруулж, заах, мөн 1 багшид ноогдох сурагчийн хэмжээг тогтоох гэх мэт аргыг ашигладаг. Бөх, таеквондо, гар бөмбөг зэргээр багш нар хувиараа явуулж байгаа сонгонууд чанартай байдаг. Мөн ганцаарчилсан сонгонууд болоод ирэхээрээ бүр л чанартай үр дүнтэй байдаг гэж үзсэн байна. Орчин үеийн хүүхдүүд маань илүү олон төрлийн сонгон, дугуйланд явдаг болсныг ч дурдаж байсан юм.

Сурагчдын одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секц нь одоогийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадаж байгаа эсэхийг нэр төрөлтэй харьцуулан дараах хүснэгтэд харууллаа. Хүснэгтээс харахад спортоор хичээллэж буй сурагчид өөрсдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна гэж үзэж байна.

Хүснэгт 23. Хэрэгцээ, шаардлагыг хангасан байдал, нэр төрлөөр

Дугуйлан, сонгон, секцийн нэр төрөл	Тийм, бүрэн хангаж чадаж байгаа	Үгүй	Хэлж мэдэхгүй байна	Нийт
Спорт	191	6	34	231
Шатар, даам	25	-	11	36
Хөгжим	41	2	8	51
Гадаад хэл	43	1	7	51
Хичээлтэй холбогдолтой нэмэлт давтлага	58	1	14	73
Бүжиг	48	2	7	57
Гар урлал	22	-	1	23
Дуу	17	-	2	19
Уран зураг	10	-	-	10
Хувь хүний хөгжил	16	-	3	19
Сэтгэн бодох чадвар	12	4	8	24
Зохион бүтээх хөдөлмөр	11	-	-	11
Бусад	3	-	1	4
Нийт	319	12	59	390


Харин эцэг эхчүүдийн дийлэнх нь хэрэгцээ, шаардлагыг хангаж чадаж байна хэмээж байгаа боловч хэт ядраахгүй, чилээхгүйгээр бие бялдар, насны онцлогт нь тохируулан зохицуулах тал дээр ихээхэн анхаардаг байна.

Хүүхдүүдийн өөрийнх нь сонирхож байгаа урлаг спорт, ЕБС-д ордог хичээлийн чиглэлийн болон гадаад хэл зэргийн чиглэлийн сургалт, сонгоноуд бол тодорхой хэмжээгээр байгаад байна. Гэтэл нийгмийн шаардлага болсон, орчин үеийн хүүхдүүдэд нэн хэрэгцээтэй ёс суртахуун, хүмүүжлийн чиглэлийн, хувь хүний хөгжлийн чиглэлийн сургалтууд бол байхгүй байгаа нь ажиглагддаг. Миний охины явдаг дугуйлангуудын тухайд хэрэгцээг бол хангаж чадаж байна. **Эцэг эхийн төлөөлөл**

Манай хүүхдийн хувьд явмаар байна сурмаар гэсэн олон зүйл сонирхдог, ядарна гэдгийг мэдэхгүй насан дээр явж байх шиг байна. ЕБС-дад 6-р ангиас дээш ангийнханд спортын төрлийн секц, дугуйлан хичээллэдэг. Харин 5-р ангийнханд бие бялдрыг хөгжүүлэх төрлийн юм байдаггүй юм байна. Тийм болохоор спортоор хичээллэж байгаа хүүхдүүд гоё, сонирхолтой харагддаг юм болов уу, би гар бөмбөгийн секц явмаар байна гэдэг. Бас япон хэл, солонгос хэл сурмаар байна гэсэн. Гэхдээ энэ төрлийн хэлний сургалтууд байдаг ч гэсэн бага насны хүүхдүүдэд чиглэсэн байдаг талаар сайн мэдэхгүй байна. Тийм болохоор илүү энэ насны хүүхдийн насны онцлог, бие бялдрын онцлогт тохирсон хэлний болон хөгжөөнт чиглэлийн дугуйлан байвал зүгээр байх. **Эцэг эхийн төлөөлөл**


Сургууль дээрээ дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж буй сурагчдын 75.7 хувь нь одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секц нь хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна хэмээн үзжээ. Харин сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвийн дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж буй сурагчдын 88.3 хувь нь өөрсдийнх нь хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадаж байна хэмээжээ.

График 14. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал, хамрагдаж буй байршлаар




Мөн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадаж байна хэмээн үзсэн сурагчдын 48.0 хувь нь сургууль дээрээ, 42.0 хувь нь сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвд хамрагддаг байна.

График 15. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал



Дараах графикт сурагчдын өөрсдийн хэрэгцээ, шаардлагыг үнэлсэн үнэлгээний хувийг орууллаа.


График 16. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал, хувиар



Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 81.8 хувь нь одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секц өөрийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж чадаж байна гэж үзсэн бол 3.1 хувь нь хангаж чадахгүй байна, 15.1 хувь нь хэлж мэдэхгүй байна хэмээжээ.

Хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан хэмээн үзсэн сурагчдын 48.3 хувь нь хөвгүүд, 51.7 хувь нь охид байсан. Харин хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байна хэмээн үзсэн сурагчдын дийлэнх нь охид байна.


График 17. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал, хүйсийн харьцаагаар



Ерөнхийдөө сурагчдын дийлэнх хувь нь сургууль дээрээ эсхүл сургалт хөгжлийн төвийн алинд нь явахаасаа үл хамааран одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секц нь өөрсдийн хэрэгцээг хангаж чадаж байна хэмээн үзжээ.

Байршлаар нь авч үзвэл Багануур дүүргийн сурагчдын хэрэгцээ, шаардлага бүрэн хангагдсан байна.

График 18. Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сурагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан байдал, байршлаар




Харин Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын сурагчдын хэрэгцээ, шаардлагыг хангасан байдал бусад байршлаас арай бага буюу 54.2 хувь, хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байгаа хувь нь бусад байршилтай харьцуулахад харьцангуй өндөр байгааг дараах графикт дүрслэн харууллаа. Энэ үзүүлэлт нь байршлын хувьд харилцан адилгүй байгаа нь тухайн байршилд явагдаж буй дугуйлан, сонгон, секцийн үйл ажиллагаа бүр нь харилцан адилгүй байгаатай холбоотой байж болох юм.

3.3.3. Одоогийн дугуйлан, сонгон секцийг сонгосон шалтгаан

Эцэг, эхчүүдийн үзэж буйгаар ихэнх тохиолдолд хүүхдийнхээ хүсэл, сонирхлыг нь нэн тэргүүнд харгалзан үздэг бөгөөд, мэдээж багшийн ур чадварыг судалж үздэг байна. Түүнчлэн спортын сонгон, секц, дугуйланд хамруулах сонирхолтой байдаг нь хүүхдийн төлөвшил, бие даах чадвар, хариуцлагатай бие хүн болж төлөвших боломжуудыг нээн хөгжүүлдэг гэж үздэгтэй холбоотой хэмээжээ.


График 19. Одоогийн хамрагдаж буй дугуйлан сонгон, секцэд хамрагдсан шалтгаан



Сурагчдын ихэнх нь хувь нь буюу 80.3 хувь нь өөрийн хүсэл сонирхлоор одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секцийн сонгосон бол 24.9 хувь нь эцэг, эхийн зөвлөснөөр, 8.7 хувь нь сургалт явуулж буй багшийн ур чадвар сайн учраас, 6.2 хувь нь багш нар уг сургалтад явуулахыг санал болгосон, 4.4 хувь нь найз нөхөд санал болгосон, 1.5 хувь нь бусад гэсэн шалтгааныг сонгожээ. Бусад гэдэгт мэргэжил сонголттой холбоотой асуудлыг хөндсөн байна.


Уг дугуйлан, сонгон, секцэд хамрагдахад найз, нөхөд санал болгосон, багш нар сургалтад явахыг санал болгосон гэсэн шалтгаануудын хувьд охид хөвгүүдээс илүү хувьтай байна. Энэ нь охид хэн нэгний зөвлөгөөг маш сайн хүлээж авдаг, хоорондоо мэдээлэл сайн солилцдог гэх мэт шалтгаантай холбоотой байж болох юм. Түүнчлэн сургалт явуулж буй багшийн ур чадвар сайн байх нь ч гэсэн охидын хувьд маш чухал байна. Эцэг, эхийн зөвлөснөөр хамрагдаж буй сурагчдын хүйсийн харьцаа ойролцоо байна.

График 20. Одоогийн хамрагдаж буй дугуйлан сонгон, секцэд хамрагдсан шалтгаан, хүйсийн харьцаагаар



Дугуйлан, сонгон, секцийг сонгосон шалтгаан нь байршлын хувьд задлан харахад зүй тогтол бүхий дүгнэлт хийх боломжгүй байна. Хот, хөдөөгийн сурагчид аль ч үзүүлэлтийн хувьд харилцан адилгүй сонголттуудыг хийжээ.

График 21. Одоогийн хамрагдаж буй дугуйлан сонгон, секцэд хамрагдсан шалтгаан, байршлаар




Сурагчдын дийлэнх хувь нь өөрсдийн хүсэл сонирхлоор одоогийн дугуйлан, сонгон, секцийг сонгож байгаа хэдий ч судалгааны явцад сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвд хамрагдахыг эцэг, эхчүүд зөвлөх нь ажиглагдсан.

3.4. СУРАГЧДЫН ЦААШДЫН ХҮСЭЛ, СОНИРХОЛ

Сурагчид цаашид ч мөн адил спортын дугуйлан, сонгон, секцэд хамрагдахыг хүсэж байгаа байгаа бөгөөд спортыг сонгосон нийт 252 сурагчийн 144 хөвгүүд, 108 нь охид байна. Харин эсрэгээрээ дуу хөгжим, урлагийн дугуйлан, сонгон, секцийг сонирхож буй сурагчдын дийлэнх нь охид байв.

График 22. Цаашид хамрагдахыг хүсэж буй дугуйлан, сонгон, секцийн төрөл



Судалгаанд хамрагдсан сурагчдын цаашид авахыг хүсэж буй дугуйлан, сонгон, секцийг тодруулахад 64.6 хувь нь спорт, 38.5 хувь нь дуу хөгжим, урлаг, 11.0 хувь нь ШУ, танин мэдэхүй, 7.2 хувь нь гадаад хэл, 5.9 хувь нь хичээлийн холбогдолтой нэмэлт сургалт, 4.9 хувь нь хувцас дизайн, гар урлал, 10.0 хувь нь хэлж мэдэхгүй, 9.5 хувь нь бусад гэх хариултыг сонгожээ. Бусад гэсэн сонголтод хувь хүний хөгжил, илтгэх урлаг, харилцааны урлаг, амьдрах ухаан, хүүхдийн зорилгыг тодорхойлж өгөх гэх мэт хариултууд ирсэн байна.

*Миний бодлоор хувь хүний хөгжил, биеэ хэрхэн авч явах вэ гэдэг талаар сонгон хичээллүүлбэл зүгээр санагддаг. Хотод Ladies & Gentlemen сургалтын төв байдаг. Тэнд хэрхэн зөв алхах гишгэх, хэрхэн олон нийтийн газар өөрийгөө зөв авч явах уу, яаж хүмүүстэй зөв харилцах уу гэх мэтээр энгийн амьдралд хэрэгтэй зүйлүүдийг заадаг. Эдгээрийг мэдэхгүйгээс хоорондоо харилцахдаа алддаг, биеэ авч явж чаддаггүй, ёс зүйн алдаа гаргадаг зэрэг нь сургууль соёл, олон нийтийн газар харагддаг. Үүнийг засч залруулах, хөгжүүлэх хэрэгтэй. Хүүхдүүд маань дан ганц эх орондоо бус, гадаадад амьдарч болно. Тэр тал дээр сэтгэлгээг нь тэлэх сонгон, дугуйлангууд хичээллүүлбэл түлхэц болох болов уу гэж боддог. Хүүхдүүд монгол ёс заншил, өв соёлоо мэдэхгүй байдаг. Багш нар нь ч бас бүрэн гүйцэд мэдэх нь сул байна. Монгол ёс, соёлоо хайрлан дээдлэх, эрхэмлэх чиглэлийн дугуйлан, секц хичээллүүлэх, нэг өдөр нь монгол тоглоом тоглуулах гэх зэргээр өв уламжлалаа сэргээн сануулах дугуйлан секц хичээллүүлбэл хэрэгтэй юм уу гэж санагддаг. **Багш нарын төлөөлөл***


Эцэг эхчүүд хувь хүний хөгжил рүү чиглэсэн дугуйлан, сонгон, секцийг нас насны онцлогт тохирсон байдлаар зохион байгуулах хэрэгцээтэй байна хэмээн үзжээ. Мөн орчин үеийн хүүхдүүд хурдацтай хөгжиж байгаа тул олон нийтийн сүлжээг ашиглах арга зүй гэх мэтээр цаг үетэйгээ холбоотой шинэ шинэ чиглэлүүдийг ч санал болгож байсан юм. Эдгээр сургалтууд нь сургууль дээрээ нэгдсэн журмаар сонголттой хичээллэж байвал төлбөр болон хүртээмжийн хувьд илүү боломжийн нөхцөлтэй болох талаар дурджээ. Энэ чиглэлд төрөөс багш нарын ур чадварыг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, анги танхимын хүрэлцээгээр хангах, төрийн байгууллагуудын уялдаа, холбоог сайжруулах шаардлагатай гэсэн саналуудыг хэлж байв.

Харин дугуйлан, сонгон, секц хичээллүүлж байгаа сургалт хөгжлийн төвийн удирдлагуудын тухайд оюуны чиглэлийн дугуйлангууд ихээхэн бий болоод байгаа ч хүүхдэд гоо зүйн мэдрэмж бий болгох дугуйлангууд шинээр гаргаж ирэх нь хэрэгтэй гэж бодож байна. Энэ тал дээр эцэг эхчүүд бас санаачилгатай байх хэрэгтэй. Багш нарт авч ирчихээд зурж сургах гээд орхидог. Гол нь тэдний бас дэмжлэг туслалцаа маш их хэрэгтэй байгаад байдаг.

*Дээр үед сургууль бүр хүүхэд хөгжүүлэх цаг гэж 2 цагийг багш нарт олгоод, урамшууллыг нь өгөөд явдаг байхад арай цэгцтэй байдаг байлаа. 1 багш цаасан урлалаар дугуйлан хичээллүүлдэг байхад, уран уншлагаар 1 багш гэх мэтээр. Одоо бол 1 багшид ноогдох 19 цагаас илүү сонгон секцийн цаг гэж байдаггүй учраас хүүхдүүдийг хөгжүүлэх сонгон секц гэж байхгүй болсон. Гэтэл эцэг эхчүүдэд хүүхдээ хөгжүүлэх хэрэгцээ байгаад байгаа учраас гадуур сайн багш олж, төлбөртэй сонгонуудад хүүхдээ өгч байна. Энэ бол төрөөс ЕБС-руу чиглэсэн, хүүхдийн авьяасыг хөгжүүлэх чиглэлийн нэгдсэн бодлого байхгүй байгааг харуулж байна. **Дугуйлан, сонгон, секц хичээллүүлж буй удирдлагуудын төлөөлөл***

Улаанбаатар хотын сурагчид хичээлийн холбогдолтой, гадаад хэлний сургалтуудад түлхүү хамрагдах сонирхолтой байна. Харин мэдэхгүй байна хэмээн хариулсан 39 сурагчийн талаас илүү хувь нь Улаанбаатар хотын сурагчид байна. Бусад дугуйлан, сонгон, секцийг сонгосон сурагчдын орон нутаг болон Улаанбаатар хотын хувь ойролцоо байна.

График 23. Цаашид хамрагдахыг хүсэж буй дугуйлан, сонгон, секцийн төрөл, байршлаар



Нийт судалгаанд хамрагдсан сурагчид цаашид дугуйлан, сонгон, секцийг сургууль дээрээ авах сонирхолтой байгаа нь 53.8 хувь, сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвд авах сонирхолтой байгаа нь 41.8 хувь байна. Харин 4.9 хувь нь хэлж мэдэхгүй байна. Өөрөөр хэлбэл 10 сурагч тутмын 5 нь сургууль дээрээ, 4 нь сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвд, 1 нь хэлж мэдэхгүй байгаа гэсэн үг юм.

График 24. Цаашид хаана дугуйлан, сонгон, секц хичээллэх нь илүү үр дүнтэй байх, хувиар



Хэдийгээр цаашид сургууль дээрээ эсхүл сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвд дугуйлан, сонгон, секцэд хамрагдах хувь ойролцоо байгаа ч сурагчид сургууль дээрээ хамрагдах хүсэл, сонирхол их байна. Нэн ялангуяа Улаанбаатар хотын сурагчид орон нутгийн сурагчидтай харьцуулахад энэхүү хүсэл сонирхол илүү байна.

Хүүхдийн урлан бүтээх төвийн зүгээс хүүхдийн хөгжилтэй холбоотой төсөл хэрэгжих гэж байна. Уг төслийн хүрээнд алслагдсан дүүрэг, хороонд сургалт явуулах, зорилтод бүлгийн сонгон, дугуйланд хамрагдах хүсэлтэй хүүхдүүдэд хүрч ажиллах юм. Манай байгууллага нь алслагдсан дүүргийн хүүхдүүдэд тухайн газар нь очиж сургалт явуулна. Хүүхдүүд тухайн цаг үедээ юу сонирхож, юу хийхийг хүсэж байна вэ? аль болох тэр чиглэлээр нь сонгон дугуйлан дугуйлан хичээллэвэл хүүхдийн сонирхох хүсэл эрмэлзэл ч гэсэн нэмэгдэнэ хэмээсэн байна. Ихэнх сургалт хөгжлийн төвүүд алслагдсан сум, дүүргийн хүүхдүүдийг сургалтад хамруулах сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Үүний тулд дугуйлан хичээллүүлж, хүүхдүүдийн авьяасыг нээж, хөгжүүлж байгаа тул хүүхдүүдийн гаргасан амжилт болон дугуйлангийн тогтвортой ажилласан байдал зэргийг харгалзан үзэж төрөөс тэтгэмж, урамшуулал олгож байх саналыг гаргасан байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар ЕБС-ууд, сурагчид, багш нарын тоо өссөөр байна. Хэдийгээр энэ нь сайшаалтай үзүүлэлт боловч 1 багшид оногдох сурагчийн тоо дунджаар 20 байна. Энэ нь багш нарын хувьд ажлын ачааллыг бий болгох, үүнээс үүдэн сурагчдыг хөгжүүлэх нэмэлт сургалтыг явуулах, ур чадвар, арга зүйгээ сайжруулах нөхцөл боломжийг хязгаарлаж байна. ОУ-ын сайн туршлага бүхий Өмнөд Солонгос, Финланд улсын тухайд багш нарыг маш их хүндэлдэг, ажиллах нөхцөл боломж, цалин хангамжаар маш их дэмжиж байна. Харин Монгол Улсын хувьд багш мэргэжил нь өнөөгийн байдлаар тийм ч эрэлттэй, өндөр цалинтай, хангамж сайтай мэргэжилд тооцогдохгүй байна.

Судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

Монгол Улсын хэмжээнд сургууль дээрээ болон сургуулиас гадуурх сургалт хөгжлийн төвд өнөөгийн байдлаар спорт, шатар, даам, хөгжим, гадаад хэл, хичээлтэй холбогдолтой нэмэлт давтлага, бүжиг, гар урлал, дуу, уран зураг, хувь хүний хөгжил, сэтгэн бодох чадвар, зохион бүтээх хөдөлмөр, бусад гэсэн 13 нэр төрлийн дугуйлан, сонгон, секцэд хамрагдаж байна. Харин дэлхийн хэмжээд сайн боловсролтой улс орнуудын хувьд 10 нэр төрлийн дугуйлан, сонгон, секц хичээллэдэг. Хэдийгээр Монгол Улсад хичээллэж буй дугуйлан, сонгон, секцийн нэр төрөл нь улс орнуудтай харьцуулахад олон байгаа боловч орчин үеийн хүүхдүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн төрөл дутагдалтай байна. Тодруулбал сайн дурын ажил, ШУ-ны туршилт, ШУ-ны тэмцээн, компьютер, технологи, харилцааны ур чадвар, хувь хүний хөгжил рүү чиглэсэн клубууд дутагдалтай байна.

Дэлхийн сайн боловсролыг эзэмшүүлдэг улс орнуудын сургуулиуд 7 хоногт 1 сурагч хэдэн цагийг ямар дугуйлан, сонгон, секцэд зарцуулж буй нарийн тооцож гаргадаг бол Монгол Улсад өнөөгийн байдлаар энэ талаар нарийвчлан тооцож гаргасан тоо баримт байхгүй байна.

Боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалтын хэмжээ сайн боловсрол эзэмшүүлдэг улс орнуудаас маш бага түвшинд байна. Бидний ОУ-ын сайн туршлагын хүрээнд судалсан Өмнөд Солонгос, Финланд улс нь 1 сурагчийг ЕБС-д суралцаж эхэлснээс эхлэн төгсөх хүртэл 10.0 орчим мянган долларыг зарцуулдаг аж. Монгол Улсын хувьд 2.0 орчим мянган долларыг зарцуулж байна. Гэвч энэхүү зардлын хичнээн хувь нь ХГҮА-д зарцуулагдаж байгаа нь тодорхой бус байна.

Бидний хийсэн судалгаагаар сургууль дээр зохион байгуулагдаж буй дугуйлан, сонгон, секцэд хамрагдахдаа сард дунджаар 29,863 төгрөгийн төлбөр төлж байгаа бол бусад сургалт хөгжлийн төвд суралцахдаа дунджаар 74,843 төгрөг төлдөг байна. Түүнчлэн гадаад хэлний дугуйлан, сонгон, секцүүд хамгийн үнэтэй буюу сард дунджаар 176,000 байлаа.

Сурагчид болон эцэг, эхчүүд одоогийн хамрагдаж буй сонгон, секц, дугуйланд сэтгэл ханамжтай байдаг төдийгүй, хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадаж байна хэмээн үзэж байна. Сурагчдын сэтгэл ханамжтай байгаа хамгийн гол шалтгаан нь өөрийн хүсэж буй зүйлдээ хамрагдаж байгаагаас хамаарч буй бол эцэг эхчүүд хүүхдийнхээ амжилт гаргаж, ахиц дэвшлийг харуулж буйд нь хамгийн их сэтгэл ханамжтай байв. Гэхдээ нийгмийн шаардлага болсон, орчин үеийн хүүхдүүдэд нэн хэрэгцээтэй ёс суртахуун, хүмүүжил, хувь хүний хөгжил технологийн чиглэлийн сургалтуудад хамрагдах байдал нь бага байгаа нь хүүхдүүд өөрсдийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн таньж чадсан эсэхэд эргэлзэхээр байна. Өөрөөр хэлбэл хүүхдүүд өөрсдийн юу хүсэж байгаага мэдэхгүй, хэрхэн хөгжих талаар мэдлэг муу байна.

Харин салбарын экспертүүд, багш нар, удирдлагууд одоогийн дугуйлан, сонгон, секцийн үйл ажиллагааны нэр төрөл, чанар хүртээмжид сэтгэл ханамж дундуур байна. Шалтгаан нь арга, аргачлал, хэрэглэгдэхүүн, багш нарын урамшуулал, анги танхим хүрэлцээгүй байгаатай холбоотой аж.

ОУ-д сургалтын программдаа нэмэлтээр хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэх хичээлүүдийг оруулж өгснөөр сургуулиас гадуурх үйл ажиллагаанд зарцуулж буй цаг хугацаа, мөнгийг хэмнэнэ хэмээн үздэг байна. Сурагчдын юу хүсэж байгааг сайтар судалсны үндсэн дээр сургалтын программд ямар төрлийн нэмэлт хичээлийг оруулж өгөхийг шийддэг. Түүнчлэн тэд сурагчдад юу зааж байгаадаа бус ямар аргачлалаар зааж байгаадаа илүү их анхаарал хандуулдаг. Хичээлийг хэрхэн үр дүнтэй заах, сурагчид юуг өөрчилбөл цаашдаа илүү сайн сурах хандлагатай байна вэ, сурах явцыг сурагчдад сонирхолтой болгох тал дээр голчлон анхаарлаа хандуулдаг байна.

Ерөнхийдөө сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааны нэр төрөл нь урьдын уламжлалт, олон жилийн турш тогтсон, ижил төрлийн үйл ажиллагаануудаас тогтсоор өнөөг хүрчээ. Гэвч дэлхийн хэмжээнд сайн боловсрол эзэмшиж буй улс орнуудын сурагчид ШУ, танин мэдэхүй, технологи, хувь хүний хөгжил рүү чиглэсэн сонгон, секц, дугуйланд түлхүү хамрагддаг. Эндээс Монгол Улсын хэмжээнд хичээллэж буй ХГҮА-ны нэр төрлийг зайлшгүй өөрчлөх, сайжруулах хэрэгцээ, шаардлага үүссэн байгаа бөгөөд шинээр бий болох дугуйлан, сонгон, секцүүдийг хичээлийн хөтөлбөрт болон ХГҮА-ны төлөвлөгөөнд тусгамаар байна.

Сургуулиас гадуурх дугуйлан, сонгон, секцийн үйл ажиллагаа, сургалтын чанар хүртээмж, үнэ төлбөрийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааны ажлын үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Бодлогын түвшинд

- Анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх, олон ээлжээр хичээллэж буй байдлыг таслан зогсоох

- Багшийн нөөц боломжийг нэмэх, багшийн ур чадвар, арга зүйг сайжруулах тал дээр олон талт ажил хийх, хүүхэд хөгжлийн чиглэлээр хийж буй ажил нь багшийн ажлын хөлс, үнэлэмжтэй холбогдох
- Шаардлагатай техник технологи, программ хангамжуудыг нэвтрүүлэх
- Хувь хүний хөгжил рүү чиглэсэн ур чадварыг бий болгох зарим нэр төрлийн үйл ажиллагааг хичээлийн хөтөлбөрт тусгаж өгөх (Жишээ нь харилцааны ур чадвар, бусдыг ойлгох чадвар г.м)
- Багш нарт бие даан санаачлан ажиллах, олон талын оролцоог нэмэгдүүлэх талын шинэлэг, агуулга, арга зүй дутмаг байгаа учраас тэднийг чадваржуулах, урамшуулах, идэвхжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах
- ХГАҮ-ны нэр төрөл бүрээр арга, аргачлалыг тусгасан нэгдсэн бодлогын зөвлөмжөөр хангах

Чанар, хүртээмж, үнэ төлбөрийг сайжруулах түвшинд

- Сурагчдын юу хүсэж буйг жил бүр тандан судлах, судалгааны нэгдсэн арга хэрэгсэлтэй болох
- Сурагчдын өөрсдийн хүсэж буй чиглэлээр өөрийгөө хөгжүүлэхэд олон боломж, чиглэл байдаг талаар танин мэдэхэд тусалсан нээлттэй хаалганы өдөрлөгийг сургуулийн хэмжээнд тогтмол зохион байгуулах
- Сурагчид одоогийн байдлаар ердийн, уламжлалт, олон жилийн турш тогтсон ижил төрлийн сонгон, секц, дугуйланд одоо ч гэсэн хамрагдсаар байна. Тиймээс “Хүүхдийн урлан бүтээх төв”, “Хүүхдийн ордон”, аймаг, нийслэлд байгаа хүүхэд хөгжлийн төвүүдэд байгаа дугуйлан, сонгон, секцийн нэр төрлийг дараах байдлаар сайжруулах саналтай байна. Үүнд:
 - ШУ танин мэдэхүй,
 - Технологи
 - Бусадтай харилцах чадвар
 - Багаар ажиллаж чадвар
 - Хувь хүний хөгжил,
 - Санхүүгийн боловсрол,
 - Сайн дурын үйл ажиллагаа
- Мөн дээрх чиглэлд сонгон, секц, дугуйланд хамрагдах нь ямар үр дүнтэй болохыг тайлбарласан ухуулга, сурталчилгаа явуулах, энэ чиглэлийн сонгон, секц, дугуйлангуудыг шинээр бий болгох хэрэгтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ЭЭХҮЙЦ-ын “Education at a Glance” 2019 оны тайлан

ЭЭХҮЙЦ-ын “PISA 2015 Results (Volume II): Policies and practices for successful schools” тайлан

“Lessons from PISA for Korea” тайлан

ЮНЕСКО-гийн “Education for all” тайлан

ХАВСРАЛТ

Судлаач бэлтгэх сургалтын зураг



Фокус бүлгийн ярилцлагын үеэрх зураг





АСУУЛГЫН ХУУДАС



Судалгаа зөвлөх үйлчилгээний
ЭС АЙ СИ ЭЙ ХХК



Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн
газар

СУРГУУЛИАС ГАДУУРХ СОНГОН, СЕКЦ, ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, СУРГАЛТЫН ЧАНАР ХҮРТЭЭМЖ, ҮНЭ ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ АСУУЛГЫН ХУУДАС

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэнд хүргэе. Судалгаа, зөвлөх үйлчилгээний "Эс Ай Си Эй" ХХК нь "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар"-ын захиалгаар энэхүү судалгааг гүйцэтгэж байна. Энэхүү судалгааны зорилго нь сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн үйлчилгээний чанар, хүртээмж, үнэ төлбөрийг тодорхойлох юм. Бид энэхүү судалгаагаар авсан мэдээллийн нууцыг Монгол Улсын "Хувь хүний тухай хууль" болон "Статистикийн тухай" хуулийн дагуу чандлан хадгалж, зөвхөн судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах болно. Энэхүү асуулгын хуудас нь зөвхөн **сургуулиас гадуурх дугуйлан, сонгон, секцэд хамрагддаг ЕБСийн сурагчдад** зориулагдсан болно.

СУДЛААЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ			
№	Асуулт	Хариулт	Тайлбар/ Алхам
1	Судлаачийн мэдээл:	Ярилцлага авагчийн дугаар: Асуулгын дугаар: Судалгаа авсан байршил: _____	

ШАЛГУУР АСУУЛТ			
№	Асуулт	Хариулт	Тайлбар/ Алхам
2	Та ямар нэгэн дугуйлан, сонгон, секцэд хамрагддаг уу?	Тийм Үгүй	1 Үгүй гэсэн бол судалгааг дуусгана уу 2
3	Та уг дугуйлан, сонгон, секцэд хамрагдахдаа хаана хамрагддаг вэ?	Сургууль дээрээ Сургуулиас гадуурх сургалт, хөгжлийн төвд Аль алинд нь	1 Аль алинд нь хэмээн 2 хариулсан бол судалгааг 3 дуусгана уу

Бүлэг 1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

№	Асуулт	Хариулт	Тайлбар/ Алхам
4	Дараах ангиллын алинд нь хамаарах вэ?	Ахлах анги Дунд анги Бага анги	1 2 3
5	Судалгаанд оролцогчийн хүйс:	Эрэгтэй Эмэгтэй	1 2
6	Нас:		
7	Амьдардаг аймаг, хот:	Ховд аймаг Булган аймаг Төв аймаг Хэнтий аймаг Улаанбаатар хот	1 2 3 4 5 <i>Нэг сонголттой</i>
8	Сургууль/сургалт хөгжлийн төвийн харьяалагдах сум, дүүрэг:	Ховд (Жаргалант) Буянт Булган Орхон Зуунмод Батсүмбэр Хэрлэн Өмнөдэлгэр Баянзүрх Сүхбаатар Баянгол Багануур	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 <i>Нэг сонголттой</i>
9	Сургууль/сургалт хөгжлийн төвийн нэр:	_____	Хоосон байж болохгүй

Бүлэг 2. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

10	Сүүлийн 1 жилийн дотор ямар дугуйлан, сонгон, секцэд хамрагдсан бэ?	_____ _____ _____	Тогтмол хамрагддаг хамгийн чухал 3 хүртэлх харцуултыг бичнэ
11	Уг дугуйлан, сонгон, секц төлбөртэй байсан уу?	Тийм Үгүй	1 Үгүй гэсэн бол 13 дугаар асуулт руу шилжинэ. 2

12	Хэрэв тийм бол хэдэн 1 сард дунджаар хэдэн төгрөгийн төлбөр төлдөг вэ?	_____	_____	_____	Энд зөвхөн төлбөртэй дугуйлан, сонгон, секцийн 1 сарын дундаж төлбөрийг бичнэ үү
13	Өөрийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секц(чанар, хүртээмж г.м) таалагддаг уу?	Огт таалагддаггүй	1	Нэг сонголттой	
		Таалагддаггүй	2		
		Дунд зэрэг	3		
		Таалагддаг	4		
		Маш их таалагддаг	5		
14	Хэрэв таалагддаггүй бол ямар шалтгааны улмаас таалагддаггүй вэ?	Багш нь сонирхолгүй байдлаар хичээлийг заадаг	1	Хамгийн чухал гэсэн 3 хүртэлх хариу尔тыг сонгоно. Бусад гэсэн бол заавал тодруулан асууна уу	
		Өөрөө сонирхолгүй	2		
		Хүүхдүүдтэй үзэл бодол нийлдэггүй	3		
		Хэт ачаалалтай байдаг, олон цагаар хичээллэдэг	4		
		Төлбөрийн хувьд хэт үнэтэй	5		
		Бусад.....	6		
15	Одоогийн хамрагдаж буй дугуйлан, сонгон, секц хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж чаддаг уу?	Тийм, бүрэн хангаж чадаж байгаа	1	Нэг сонголттой	
		Үгүй	2		
		Хэлж мэдэхгүй байна	3		
16	Яагаад уг дугуйлан, сонгон, секцэд хамрагддаг вэ?	Эцэг, эхийн зөвлөснөөр	1	Хамгийн чухал гэсэн 2 хүртэлх хариу尔тыг сонгоно. Бусад гэсэн бол заавал тодруулан асууна уу	
		Өөрийн хүсэл, сонирхлоор	2		
		Сургалт явуулж буй багшийн үр чадвар сайн учир	3		
		Багш нар уг сургалтад явахыг зөвлөсөн	4		
		Найз нөхөд санал болгосон	5		
		Бусад.....	6		
Бүлэг 3. ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА					
15	Цаашид ямар төрлийн дугуйлан, сонгон, секц шинээр бий болвол таалагдах вэ?	_____	_____	_____	Хамгийн чухал гэсэн 3 хүртэлх хариу尔тыг бичнэ үү
17	Хүссэн мэдлэг, үр чадвараа эзэмшиж чадах дугуйлан, сонгон, секцийг ямар хэлбэрээр явуулах нь үр дүнтэй байхаар байна вэ?	Сургууль дээр	1	Нэг сонголттой	
		Сургуулиас гадуурх сургалт, хөгжлийн төвд	2		
		Хэлж мэдэхгүй байна	3		

Утасны дугаар:

МАНАЙ СУДАЛГААНД ОРОЛЦСОН ТАНД БАЯРЛАЛАА